

Барилгын норматив баримт бичгийн тогтолцоо
МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН НОРМ БА ДҮРЭМ

КАДАСТРЫН ЗУРАГЛАЛЫН АЖИЛ

БНБД 11-11.....

Албан ёсны хэвлэл

**МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ**

Улаанбаатар хот
2021 он

Барилгын норматив баримт бичгийн тогтолцоо
МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН НОРМ БА ДҮРЭМ

**КАДАСТРЫН
ЗУРАГЛАЛЫН АЖИЛ**

БНБД 11-11.....

Албан ёсны хэвлэл

**МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ**

Улаанбаатар хот
2021 он

1. Монгол Улсын Барилга, хот байгуулалтын яамны 2020 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 39/2020 дугаар норм, дүрмийг шинэчлэн боловсруулах ажлын техникийн даалгавараар боловсруулав.

2. Монгол Улсын Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны ...дугаар сарын ...ны өдрийн ...тоот тушаалын хавсралтаар батлав.

3.Хууль зүй, дотоод хэргийн яамны хууль зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд 2021 оны ... дугаар сарын ...өдрийндугаарт бүргэсэн.

4.Кадастрын зураглалын ажил БНБД 11-11-...ыг 2021 оны ...дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

БОЛОВСРУУЛСАН:

Г.НАРАНТУЯА

Монгол Улсын геодезийн зөвлөх инженер

ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН:

ШҮҮМЖ ХИЙСЭН:

Энэхүү нормативын баримт бичгийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр бүрэн болон хэсэгчлэн хувилах, олшруулах, тараахыг хориглоно.

МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН НОРМ БА ДҮРЭМ

КАДАСТРЫН ЗУРАГЛАЛЫН АЖИЛ**WORK OF CADASTRAL MAPPING**

НЭГ.ЕРӨНХИЙ ХЭСЭГ**1.1.ХЭРЭГЛЭХ ХҮРЭЭ**

1.1.1. Энэ норм ба дүрмийг Монгол Улсын нутаг дэвсгэрт улсын хилийн дотор газрын, хот байгуулалтын, инженерийн шугаман байгууламжийн, геологи, уул уурхайн, байгаль орчны болон бусад бүх төрлийн кадастрын зураглалыг газар, түүний хэвлийд өмчийн хэлбэрээс үл хамааран хуульд заасан нарийвчлалтай үйлдэх, тогтоосон солбицолоор газар дээр эргэлтийн цэгийн байрлалыг тогтоох, олох, тэмдэгжүүлэх, төрийн цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын мэдээллийн санд бүртгэх, өөлчлөлт оруулах, хэвлэж баталгаажуулах, кадастрын зурагт үндэслэсэн мэдээллийн сан хөтлөх, нийтэд үйлчилгээ үзүүлэх, технологийн дамжлага, үе шатанд хяналт тавих, магадлан болон давтан хэмжилт хийх, зөрчил, маргааныг хянан шийдвэрлэх, үнэлэлт, дүгнэлт өгөх зэрэг бусад үйл ажиллагаанд нийтээр мөрдөнө.

1.1.2. Бүх ангилалын бүх төрлийн болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж, ашиглаж, өмчилж байгаа газар, түүний хэвлийд байрлах барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ болон бусад объект, эд зүйлсийн байрлал, хэмжээг 2 буюу түүнээс дээш хэмжээгээр тогтооход мөрдөнө.

1.1.3. Ой, усан сан бүхий газар, онцгой, энгийн хамгаалалт, эрүүл ахуйн бүс, хуульд заасан бусад хамгаалалтын бүс, тэдгээрийн хил зааг, байрлал, хэмжээг тогтооход мөрдөнө.

1.1.4. Аймаг, нийслэл, хот, тосгон, сум, дүүрэг болон тусгай хэрэгцээний газрын батлагдсан солбицолоор тэдгээрийн хил зааг, эргэлтийн цэгийг газар дээр тогтоох, шалгахад мөрдөнө.

1.2. НОРМАТИВ ИШЛЭЛ

1.2.1. Энэхүү барилгын норм ба дүрэмд А хавсралтад заасан норм, нормативын баримт бичгийн заалтуудыг ашигласан болно.

1.2.2. Барилгын норм ба дүрэм батлагдсанаас хойш ишлэл авсан баримт бичигт нэмэлт, өөрчлөлт хийсэн, шинэчилсэн байвал тэдгээр нэмэлт, өөрчлөлт хийсэн буюу шинэчилсэн баримт бичгийг мөрдөнө.

1.3. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.3.1. Кадастрын зураглалыг Монгол улсад геодезийн хэмжилт зураглалын ажилд ашиглаж буй байрлал, өндрийн тогтолцоо, эринд гүйцэтгэнэ.

1.3.2. Засаг захиргааны нэгж аймаг, нийслэл, сум, дүүрэг, хот, тосгон, баг, хороо болон тусгай хэрэгцээний газрын кадастрын зураг үйлдэхдээ УИХ, Орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан хилийн цэсийн солбицолоор тэдгээрийн хил зааг, эргэлтийн цэгийг газар дээрх хэмжилтээр тогтоож, тэмдэгжүүлж, цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын мэдээллийн санд бүртгэнэ.

1.3.3. Бүх ангилалын бүх төрлийн кадастрын зураглал үйлдэхдээ геодезийн хээрийн хэмжилт, суурин арга, тэдгээрийн хосолсон аргуудаар нарийвчлалын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэнэ.

1.3.4. Бүх ангилалын бүх төрлийн кадастрын зураглал үйлдэхдээ газар, түүний хэвлийд байрлах барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, объектууд, эд зүйлс тэдгээрт хамаарах энгийн, онцгой, эрүүл ахуйн болон хуульд заасан бусад хамгаалалтын бүсийн хамт зураглана.

1.3.5. Бүх ангилалын бүх төрлийн кадастрын зураглал үйлдэхдээ тухайн газарт өмнө гүйцэтгэсэн байр зүйн болон дэвсгэр зургийн масштабыг томруулан ашиглахыг хориглоно.

1.3.6. Бүх ангилалын бүх төрлийн кадастрын зураглал үйлдэхдээ масштабын нарийвчлалын шаардлага хангах агаар, сансрын зураг ашигласан бол тэдгээрийн боловсруулалтыг технологийн дагуу хийсэн байна. /бусад норм дүрмээс холболт хийх/

1.3.7. Эрхийн харилцаа үүссэн бүх ангилалын бүх төрлийн газарт кадастрын зураглал үйлдэхдээ нэгж талбарын эргэлтийн цэгүүдийг газарт тэмдэгжүүлэх мэдэгдлийг үндэслэн солбицолыг газар дээр олж тэмдэгжүүлж, нэг бүрчлэн хэмжиж зураглана.

1.3.8. Бүх ангилалын бүх төрлийн кадастрын зураглал үйлдэхдээ байрлал, өндрийн нарийвчлалын шаардлага хангах геодезийн хэмжилтийн багаж, тоног төхөөрөмж ашиглана.

1.3.9. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь шинээр газар эзэмших ашиглах хүсэлт гаргах бол хэмжээ, байршил, нэгж талбарыг харуулсан кадастрын зургийг Д хавсралтын дагуу хийлгэж өргөдөлд хавсаргана. Өргөдөлд хавсаргасан кадастрын зургийг төрийн цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын мэдээллийн санд бүртгэсэн байна. Өргөдөлд хавсаргасан кадастрын зураг нь төрийн цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдээгүй тохиолдолд газар эзэмших, ашиглах, өмчлөх шийдвэрийн төсөл боловсруулах, гаргахыг хориглоно.

1.3.10. Төрийн цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын мэдээллийн санд бүртгэх кадастрын зураг нь дараах бүрдэлтэй байна.

1. эрхийн харилцаа үүссэн газрын эргэлтийн цэгийг газарт бэхлэх тэмдэгжүүлэх мэдэгдэл,

2. эргэлтийн цэгийг газарт бэхэлж, тэмдэгжүүлэн хүлээлгэн өгсөн акт,

3. кадастрын зураг

~~1.3.11. Эрхийн харилцаа үүссэн газрын эргэлтийн цэгийг газарт бэхлэх, тэмдэгжүүлэх мэдэгдэл, кадастрын зургийн солбицолтой тулгаж, нарийвчлалын шаардлага хангасан эсэхийг хянаж, эргэлтийн цэг газарт тэмдэгжүүлэн хүлээлгэн~~

өгсөн актыг газар зохион байгуулагч гарын үсэг зурж баталгаажуулж, төрийн цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын мэдээллийн санд бүртгэнэ.

1.3.12. Эрхийн харилцаа үүссэн газрын кадастрын зургийн солбицолоор төрийн цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын мэдээллийн санд бүртгэж нэгж талбарын дугаар олгож, нэгж талбарын кадастрын зургийг 2 хувь хэвлэн, баталгаажуулж, 1 хувийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад, 1 хувийг энэ норм ба дүрмийн 1.3.10 дахь хэсэгт заасан бүрдэлийн хамт эх хувиар нэгж талбарын хувийн хэрэгт хадгална.

1.3.13. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр нэгж талбарын кадастрын зурагт өрсөн өөрчлөлтийг үндэслэн төрийн цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулж болно.

1.3.14. Эргэлтийн цэгийг газарт тэмдэгжүүлэн бэхэлсэн кадастрын зураг нь бүрдэл хангаагүй бол төрийн цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын мэдээллийн санд бүртгэхийг хориглоно.

1.3.15. Бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газарт эзэмшигч, ашиглагч, өмчлөгчийг тогтоохгүйгээр, газар, түүний хэвлийд байрлах ямар нэг эд зүйлс, объектой давхцуулж кадастрын зураглал үйлдэхийг хориглоно.

1.3.16. Төрийн цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын мэдээллийн санд бүртгэсэн кадастрын зурагт үндэслэн лавлагаа болон түүхийн нэгдсэн зургийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр үнэн зөв хөтөлнө.

1.3.17. Бүх ангилалын бүх төрлийн кадастрын зураглалд орох өөрчлөлтийг мэдээллийн санг хөтлөж байгаа байгууллага нэгж талбар бүрээр тухай бүр нь мэдээллийн санд бүртгэж, төрийн цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын зураглалын мэдээллийн санд жилд нэг удаа тулгалт хийж, өөрчлөлтийг оруулсан байна.

1.3.18. Газрын нэгдмэл сангийн үндсэн, дэлгэрэнгүй ангилалд орж байгаа өөрчлөлт, хөдөлгөөний тайлан, газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл, эсхүл газрын улсын бүртгэлийг Төрийн цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын мэдээллийн сангийн кадастрын зурган мэдээлэлийг үндэслэн гаргана.

1.3.19. Газрын нэгдмэл сангийн бүх ангилалын газарт газрын кадастрын судалгааны ажил гүйцэтгэхдээ тогтоосон төрөлд масштабын нарийвчлалыг хангасан кадастрын зургийг ашиглан гүйцэтгэнэ.

1.3.20. Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас геодези, зураг зүйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй, тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь кадастрын зураглалын хэмжилт хийх, хэмжилттэй холбоотой акт, баримт бичиг үйлдэхийг хориглоно.

1.3.21. Кадастрын зураглалтай холбоотой геодезийн хэмжилт хийх, хэмжилтийн нарийвчлал, стандартын шаардлага хангаагүй, эргэлтийн цэгийг газарт тэмдэгжүүлж, бэхлээгүй кадастрын зураг үйлдэх, нэгж талбарын эргэлтийн болон геодезийн цэг тэмдэгтийг хамгаалаагүй, устгасан, кадастрын зурагтай холбоотой газрын кадастрын материалд засвар хийсэн, газрын нэгдсэл сангийн

тоо бүртгэл, улсын бүртгэлийг буруу хийснээс үүссэн хохиролыг тогтоолгож, нөхөн төлүүлнэ.

1.3.22. Кадастрын зураглалтай холбогдож үүссэн учирсан хохирол, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо Геодези, зураг зүйн жишиг үнэ БД 81-103-21 болон холбогдох хууль, төрийн захиргааны төв, төрийн захиргааны байгууллагаас баталсан стандарт, норм, дүрэм, журмыг баримтлана.

1.3.23. Кадастрын зураглал үйлдэх үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үүргийн дагуу оролцож, саад учруулахгүй, хөндлөнгөөс оролцохгүй байвал зохионо.

1.3.24. Кадастрын зураглалын үнэн зөв байдлыг гүйцэтгэгч аж ахуйн нэгж, кадастрын зурагтай холбоотой Төрийн цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын мэдээллийн сангийн бүртгэлтэй холбоотой мэдээллийн үнэн зөв байдлыг тухайн ангилалын мэдээллийн санг хөтлөж буй байгууллага хариуцна.

1.3.25. Бүх төрлийн бүх ангиллын газар, барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээ болон эд зүйлс, объектод онцгой, энгийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсэд хамаарах газрын байрлал, хэмжээ, хил зааг тэдгээрийн эргэлтийн цэгт кадастрын зураглал үйлдэхдээ тухайн бүсэд хамаарах гарсан шийдвэрийг үндэслэн тогтооно.

1.4. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

1.4.1. Барилгын норм ба дүрэмд тусгагдсан нэр томъёоны тодорхойлолтыг Б хасралтад заасан утгаар ойлгоно.

ХОЁР. КАДАСТРЫН ЗУРГИЙН АНГИЛАЛ

Кадастрын зураглалыг Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан газрын, хот байгуулалтын, инженерийн шугаман байгууламжийн, геологи, уул уурхайн болон бусад гэсэн ангилалаар үйлдэнэ.

2.1. Газрын кадастрын зураглал.

2.1.1. Газрын кадастрын зураглалыг Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дэх хэсэгт заасан газрын үндсэн зориулалт, хэрэгцээг харгалзан газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллаар газар, хөрс, ус, ургамлын байр зүйн агуулгатайгаар 2 буюу түүнээс дээш хэмжээсээр орон зайд үйлдэнэ.

2.1.2. Газрын кадастрын зураглалыг нэгдмэл сангийн ангилалаар үйлдэхдээ Газрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасныг баримтлана.

2.1.3. Нэг хил зааг бүхий газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангилал тус бүр нь тоо бүртгэлийн нэг нэгж талбар гэж үзэн кадастрын зураглал үйлдэж мэдээллийн санд оруулна.

2.1.4. Газрын нэгдмэл сангийн хөдөө аж ахуйн ангилалын газрын кадастрын зураглалыг бэлчээр, хадлан, тариалан, атаршсан газар, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн газар, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулсан бусад

газрын хил зааг, тэдгээрт байрлах объектуудад 2 буюу түүнээс дээш хэмжээсээр орон зайд үйлдэнэ.

1. Бэлчээрийн газрын кадастрын зураглалыг газрын нэгдмэл сангийн ангилалын хот, тосгон, бусад суурин газрын суурьшлын бүсийн хил заагаас гадна байрлах газарт үйлдэнэ.

2. Хот, тосгон, бусад суурин газрын суурьшлын бүсийн хил заагаас гадна байрлах авто, төмөр зам, газрын гадаргуу, хөрс, агаарын орон зай, газрын хэвлийд байрлах цахилгаан, холбоо мэдээллийн дамжуулах шугамын хамгаалалтын зурвас газарт тусгайлан хамгаалалтын хашаа, хайс баригдаагүй газрыг бэлчээрийн газар хамруулж кадастрын зураглалыг үйлдэнэ.

3. Хадлангийн газрын кадастрын зураглалыг тэжээл бэлтгэх зориулалтаар ашиглаж буй газар, барилга, байгууламж, дэд бүтэц байрлах газарт үйлдэнэ.

4. Тариалангийн газрын кадастрын зураглалыг тариалсан, уриншилсан, өнжөөсөн, атаршсан, тариалангийн талбайн эргэлт-ашиглалтын зурвас, тариалангийн үйлдвэрлэлтэй холбоотой хөдөө аж ахуйн туршилт, судалгаа, тариалангийн болон эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай үл хөдлөх эд хөрөнгө, дэд бүтцийн газарт үйлдэнэ. /тариалангийн тухай хуулийн 6.2, дахь хэсэг, 13 дугаар зүйл/

5. Тариалангийн зориулалтаар эрхийн харилцаа үүссэн газарт Тариалангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт заасан тарималын үйлдвэрлэлээс гадна тариалангийн талбайн гадна хэсэг дэх эргэн тойрон 100 метр хүртэл эргэлт-ашиглалтын болон ойн зурвас газрыг хамруулж үйлдэнэ. /тариалангийн тухай хуулийн 11.1, 21.1, 16.2, дахь хэсэг, 13 дугаар зүйл/

6. Атаршсан газар нь тариалангийн газарт хамаарах бөгөөд гурван жил тариалалт, уранш хийгдээгүй тариалангийн газар болон тус газарт орхигдсон үл хөдлөх эд хөрөнгө, дэд бүтцийн газарт үйлдэнэ. /тариалангийн тухай хуулийн 10 дугаар зүйл/

7. Тариалангийн газрын кадастрын зураглалыг Тариалангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасан ангилалаар үйлдэж болно.

8. Хар тамхи, мансууруулах болон хордуулах үйлчилгээтэй таримал тарьсан талбайг тариалангийн газарт хамруулж зураглахгүй, түүнийг хөдөө аж ахуйн эвдэрсэн газарт хамруулна. /тариалангийн тухай хуулийн 16.3 дугаар хэсэг/

9. Хөдөө аж ахуйн барилга, байгууламжийн газрын кадастрын зураглалыг өвс тэжээл хадгалах, мал эмнэлгийн үйлчилгээ, үтрэмийн талбай, агуулах зэрэг хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд ашиглаж буй барилга, байгууламж, дэд бүтцийн газарт үйлдэнэ.

10. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулсан бусад газрын кадастрын зураглалыг энэ норм ба дүрмийн 2.1.3-ын 1, 2, 3, 6, 7-д заасан хэсгүүдээс бусад хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглаж буй газар, барилга, байгууламж, дэд бүтцийн газарт үйлдэнэ.

11. Хөдөө аж ахуйн хэрэгцээнд тохиромжгүй газарт бэлчээрийн, хадлангийн, тариалан, хөдөө аж ахуйн барилга, байгууламжийн газарт байрлах элсэн манхан, элсэрхэг, хад, асга, шал сайр бүхий хүн, мал, техник хүрэх боломжгүй, өвөрмөц тогтоц бүхий газрыг хамруулж кадастрын зураг үйлдэнэ.

12. Хөдөө аж ахуйн газрын кадастрын зураглал үйлдэхдээ хот, тосгон, аймаг, сум, баг хороодын авто замыг хааж хэмжилт хийж, зураглахыг хориглоно.

13. Хөдөө аж ахуйн ангилалын газарт хуулиар зөвшөөрснөөс бусад үйл ажиллагааны улмаас ашигласан газрыг эвдэрсэн газар гэж үзэж кадастрын зураглал үйлдэнэ.

14. Хөдөө аж ахуйн ангилалын газрын кадастрын зураглалыг бэлчээр, хадлан, усалгаатай тариалан, усалгаагүй тариалан, атаршсан газар, хөдөө аж

ахуйн барилга, байгууламжийн дэвсгэр, ашиглахад тохиромжгүй, хөдөө аж ахуйн үйл ажиллагаанаас эвдэрсэн газар газар гэсэн дэд ангилалд хамруулж тусгайлсан дугаар бүхий давхраг /Lcod/-д 1 дүгээр хүснэгтийг баримтлан үйлдэнэ.

1 дүгээр хүснэгт

Хөдөө аж ахуйн газрын дэд ангилал,
зураглал үйлдэх давхрага, дугаар, /код/

Д.Д	Дэд ангилал	Кадастрын зураглалын давхрагийн нэр /ашиглалтын зориулалтаар/	Давхра- гын дугаар /Lcode3/	Кадастрын зураглал үйлдэх арга зүй
1	Бэлчээр	өвөл-хаврын	1101	Бэлчээрийн нэгж талбарын кадастрын зураглалыг үйлдэхдээ ашиглалтын зориулалтаар нь ангилан, нэгж талбарын эргэлтийн цэгийг газарт бэхэлж, хүлээлгэж өгсөн акт үйлдэж, кадастрын зураг үйлдэнэ.
		зун-намрын	1102	
		сум дундын отрын	1103	
		алслагдсан	1104	
		бартаа ихтэй	1105	
		усжуулагдаагүй	1106	
		хаддаг бэлчээр	1107	
2	Хадлан	ердийн	1201	Хадлангийн нэгж талбарын кадастрын зураглалыг үйлдэхдээ ашиглалтын зориулалтаар нь ангилан, нэгж талбарын эргэлтийн цэгийг газарт бэхэлж, хүлээлгэж өгсөн акт үйлдэж, кадастрын зураг үйлдэнэ.
		усалгаатай	1202	
3	Усалгаатай тариалан	үр тариа	1301	Тариалангийн газрын нэгж талбарын кадастрын зураглал үйлдэхдээ ашиглалтын зориулалтаар нь ангилан, цэгийг газарт бэхэлж, хүлээлгэж өгсөн акт үйлдэж, кадастрын
		төмс, хүнсний ногоо	1302	
		тэжээлийн ургамал	1303	
		техникийн ургамал	1304	
		жимс жимсгэнэ	1305	
		эмийн болон гоёлын ургамал	1306	
4	Усалгаагүй тариалан	үр тариа	1401	хүлээлгэж өгсөн акт үйлдэж, кадастрын
		төмс, хүнсний ногоо	1402	

		тэжээлийн ургамал	1403	зураг үйлдэнэ.
		техникийн ургамал	1404	
		жимс жимсгэнэ	1405	
		эмийн болон гоёлын ургамал	1406	
5	Атаршсан газар	50%-иас дээш ургамлан бүрхэвчтэй	1501	Атаршсан газрын кадастрын зураглал зориулалтаар нь ангилан, цэгийг газарт бэхэлж, хүлээлгэж өгсөн акт үйлдэж, кадастрын зураг үйлдэнэ.
		50%-иас доош ургамлан бүрхэвчтэй	1502	
6	ХАА-н барилга, байгууламжийн дэвсгэр газар	өвөлжөө, хаваржаа	1601	ХАА-н барилга, байгууламжийн дэвсгэр газрын кадастрын зураглал үйлдэхдээ зориулалтаар нь ангилан, цэгийг газарт бэхэлж, хүлээлгэж өгсөн акт үйлдэж, кадастрын зураг үйлдэнэ.
		мал эмнэлгийн үйлчилгээний цэг	1602	
		үтрэм	1603	
		ХАА-н машин, механизмын хашаа, гараж	1604	
		тэжээл, бордооны агуулах	1605	
		ХАА-н үйлдвэрлэлийн цогцолбор	1606	
		хүлэмж, дарлага	1607	
		тариалангийн талбай хоорондын зурвас газар	1608	
		тариалангийн талбайн хамгаалалтын ойн зурвас	1609	
		бэлчээр дэх уст цэг	1610	
		зоорь	1611	
7	Ашиглахад тохиромжгүй газар	элсэн манхан, элсэрхэг газар	1701	Атаршсан газрын кадастрын зураглал зориулалтаар нь ангилан, мэдээллийн сан үүсгэх бүртгэл хөтөлнө.
		хад асга, шал сайр	1702	
8	Эвдэрсэн газар	Хөдөө аж ахуйн ангилалын газарт хуулиар зөвшөөрснөөс бусад үйл ажиллагааны	1801	Эрхийн харилцаа үүссэгүй болон эрхийн харицаа үүссэн боловч

		улмаас ашигласан газар	<p>эзэмшиж ашиглаж байгаа газрын эргэлтийн цэг, хил заагаас илүү хэмжээгээр эзэмшсэн газар, ХАА-н ангилалын газарт хуулиар зөвшөөрснөөс өөр зориулалтаар ашигласан газарыг хамруулан зураглана.</p> <p>Эрх бүхий Засаг даргын захирамжгүй ашигласан, болон хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд хөрс, бохирдуулсан дордуулсан, ашигласан үед Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахад хөдөө аж ахуйн ангилалын газарт хохирол, нөхөн төлбөр тооцох нөхцөлийг бүрдүүлэх</p>
--	--	------------------------	--

2.1.5.Газрын нэгдмэл сангийн хот, тосгон, бусад суурины ангилалын газрын кадастрын зураглал үйлдэхдээ хот, тосгон, бусад суурины барилга, байгууламж, үйлдвэр, уурхайн дэвсгэр, нийтийн эдэлбэрийн, нийтийн эзэмшлийн газар, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг 2 буюу түүнээс дээш хэмжээсээр орон зайд гүйцэтгэнэ.

1.Аймаг, нийслэл, хот, тосгон, бусад засаг захиргааны нэгжийн баг, хороо, дүүргийн газрын кадастрын зургийг үйлдэхдээ Улсын Их Хурлын тогтоол болон орон нутгийн Игэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан хилийн цэсийн солбицолыг газар дээр тэмдэгжүүлж газрын кадастрын зураг үйлдэж, төрийн цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын мэдээллийн санд бүртгэнэ.

2. Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалын газар болон аймаг, нийслэл, сум, дүүрэг, хотхон, баг, хорооны хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгүүдийг газарт бэхлэх, тэмдэгжүүлэх, шалгалтын болон магадлан хэмжилт хийх мэдэгдэлийг захиалагч байгууллага В хавралтын дагуу бичиж, Г хавсралтын дагуу хүлээн авна.

3. Эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгэгдэх барилгын газрын кадастрын зургийг барилгын үндсэн давхрагаар үйлдэнэ. Барилгын үндсэн давхрагад барилгын үндсэн хийцээс салгаж үл болох консаль, балконы хэсгийг оруулан байр зүйн агуулгаар үйлдэнэ. Кадастрын зурагт талбайн хэмжээг үндсэн давхрага, консаль, балконы хэсгээр өөрчлөгдсөн хэсэг бүрт талайн хэмжээг үзүүлсэн байна.

4. Үйлдвэрийн газрын кадастрын зургийг эрх бүхий Засаг даргын захирамжаар олгосон газар болон үйлдвэрийн технологийн дагуу ашиглаж байгаа бусад объектын хамт зураглана.

5. Уурхайн дэвсгэр газрыг ашигт малтмал ашиглах, хайх тусгай зөвгөөрлийн талбайн хэмжээгээр зураглана.

6. Нийтийн эдэлбэрийн газарт хот, тосгон, бусад суурины гудамж, талбай, зам, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн бус амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэг, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай зэрэг газрыг хамааруулан тэдгээрийг ангилал бүрээр нь ялгаж кадастрын зураг үйлдэнэ.

6.1. Нийтийн эдэлбэрийн газрын хил зааг тэдгээрийн хамгаалалтын бүсийг зураглахдаа тухайн газарт хийгдсэн масштаб, нарийвчлалын шаардлага хангах байр зүйн болон дэвсгэр тоон зураг, кадастрын зураг, агаарын зургийг суурь болгон ашиглаж болно.

6.2. Нэрэмжит талбай буюу түүх, соёлын хөшөө, дурсгалтай эсвэл тодорхой нэрээр нэрлэгдсэн засаж тохижуулсан талбай, нийтийн автомашины зогсоолыг аж ахуйн нэгж, байгууллага, үзвэр үйлчилгээний газруудын өмнөх автомашины нийтийн зогсоолын хэлбэрээр ашиглаж байгаа засаж тохижуулсан хэсгийн замын хашлагын гадна ирмэгээр зураглана. Автомашины замын хэсэгтэй зах нийлсэн байвал замын зорчих хэсгийг нь хасаж хил зааг тогтоож кадастрын зураглал үйлдэнэ.

6.3. Оршуулгын газрыг Засаг даргын захирамжаар тогтоосон хил зааг, хамгаалалтын бүсийн хамт үйлдэнэ.

6.4. Аюултай болон хог хаягдлын цэгийн кадастрын зураглал, түүний эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хамт үйлдэнэ.

6.5. Оршуулгын газар, аюултай болон хог хаягдлын цэгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн эргэлтийн цэгээр тогтоогдсон хил заагаас гадна нь Ариун цэврийн тухай хууль холбогдох стандартад заасны дагуу тогтооно.

6.6. Шатахууныг хүлээн авах, хадгалах, тээврийн хэрэгслийг шатахуунаар цэнэглэх, хэрэглэгчдэд жижиглэн худалдаалах зориулалттай барилга байгууламжийн цогцолбор, орох гарах зам, технологийн худгууд, шатахуун нөөцлөх сав бүхий шатахуун түгээх станцын аюулгүйн бүс 100 м байна.

6.7. Хот тосгон бусад суурин газрын төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн орчимд хамгаалалтын бүсийг 200 метр, эрүүл ахуйн бүсийг 50 метр өргөнтэй байна. Гол, үерээс хамгаалах сувгийн газарт голын эх ундрага, түүний

урсацын гольдрол, үерээс хамгаалах зориулалтаар барьж байгуулсан далан суваг болон хамгаалалтын бүсийн хил заагийг хамааруулна.

6.8. Хот, тосгон, бусад суурин дахь нэг хил зааг бүхий нийтийн эдэлбэр газар нь нэг нэгж талбар байна. Нийтийн эдэлбэр газрын нэгж талбарыг дугаарлахдаа эрх бүхий этгээдийн баталсан журмыг баримтална. /Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын даргын 2010 оны 16 дугаар тушаалаар баталсан “Нэгж талбар дугаарлах журам”/

7.Нийтийн эдэлбэр газарт барилга, байгууламж болон бусад объектод тогтоосон хориглох, хязгаарлах, эрүүл ахуйн, хамгаалалтын, аюулгүйн бүсийг хамрааруулж кадастрын зураг үйлдэж, төрийн цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын мэдээллийн санд бүргэсэн байна.

8.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад олгосон газрын кадастрын зураглалыг энэ норм ба дүрмийн 2.5 дахь хэсгээр зохицуулна.

9.Хот, тосгон, бусад суурины газрын кадастрын зураглалыг 2 дугаар хүснэгтэд заасны дагуу үйлдэнэ.

2 дугаар хүснэгт

Хот, тосгон, бусад суурины газрын кадастрын зураглалын
дэд ангилал, давхрага, дугаар

Д.Д	Ангилал	Ашиглалтын зориулалт	Код /Lcode3/	Зураглал үйлдэх арга зүй
1	Барилга, байгууламжийн газар	төрийн захиргааны байгууллага	2101	нэгж талбарын кадастрын зураглал үйлдэнэ.
		шинжлэх ухааны байгууллага	2102	
		урлаг, соёлын байгууллага	2103	
		боловсролын байгууллага	2104	
		эрүүл мэндийн байгууллага	2105	
		банк, санхүүгийн байгууллага	2106	
		биеийн тамир, спортын байгууллага	2107	
		нам, олон нийтийн байгууллага	2108	
		сүм, хийд, шашны байгууллага	2109	
		зочид буудлын цогцолбор	2110	
		худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	2111	
		дэд бүтцийн байгууллага	2112	

		музей, түүх, соёлын дурсгалт газар	2113	
		гадаадын шашны байгууллагын газар	2114	
		автомашины засвар үйлчилгээний цэг	2115	
		автомашины гараж	2116	
		шатах, тослох материал түгээгүүрийн газар, агуулах, ШТС	2117	
		ус түгээх цэг	2118	
		автотээврийн үйлчилгээний зориулалтын барилга, байгууламж	2119	
2	Суурьшлын газар	9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц	2201	
		5-8 давхар нийтийн орон сууц	2202	
		4 ба түүнээс доош давхар нийтийн орон сууц	2203	
		амины орон сууц	2204	
		гэр, орон сууцны хашааны газар	2205	
		гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газар	2206	
3	Үйлдвэрийн газар	үйлдвэрийн албан контор	2301	
		үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар	2302	
4	Нийтийн эдэлбэрийн газар	иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн бус амралт, зугаалга, биеийн тамирын зориулалтын газар	2401	Эрх зүйн харилцаа үүссэн бол хилийн шугамын эргэлтийн цэгийг тэмдэгжүүлж хашаатай бол гадна ирмэгээр, хил хязгаар нь тодорхой бус тохиолдолд хил залгаа зам болон объектын гадна ирмэгээр, зам,
		нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлж, зүлэгжүүлсэн талбай	2402	
		цэнгэлдэх хүрээлэн, наадмын талбай	2403	

		нэрэмжит талбай, хөшөө, дурсгалын газар	2404	объектгүй тохиолдолд эзэлж байгаа бодит хэмжээ, заагаар болон тусгайлан засаж тохижуулсан талбайн гадна ирмэгээр нь нэгж талбарын кадастрын зураглал үйлдэнэ.
		тоглоомын талбай	2405	
		эзэмшил, ашиглалтанд олгогдоогүй сул чөлөөтэй газар	2406	Эзэмших, ашиглах, өмчлөх боломжтой боловч эрхийн харилцаа үүссээгүй газар
		хогийн цэг	2407	Код 2401-2405 ижил аргачлалаар кадастрын зураглал үйлдэнэ.
		оршуулгын газар	2408	
		нийтийн эзэмшлийн бусад газар	2409	
		морин уралдааны бариа, автоспортын уралдааны газар	2410	
		нурсан барилга, балгас	2411	
		усан оргилуур	2412	
		хүүхдийн зуслан	2501	
5	Амралт, аялал жуулчлалын газар	амралтын газар	2502	нэгж талбарын кадастрын зураглал үйлдэнэ.
		аялал, жуулчлалын бааз	2503	
		рашаан, сувиллын газар	2504	
6	Уурхайн дэвсгэр газар	ашиглалт, олборлолт явуулж буй талбай	2601	
		уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж	2602	
		нөөц газар	2603	
7	Эвдэрсэн газар		2604	

2.1.6. Газрын нэгдмэл сангийн **зам, шугам сүлжээний** ангилалын **газрын** кадастрын зураглал үйлдэхдээ цахилгаан, дулаан, хий, ус хангамж, ариутгах татуурга, зам, замын зурвас газар, тээвэр, холбоо, мэдээллийн зориулалтаар хот, тосгон, бусад суурины гадна олгогдсон газрын хил зааг, тэдгээрт байрлах объектууд, хамгаалалтын зурвасын хамт үйлдэнэ. Зам шугам сүлжээний ангилалын кадастрын зураглалыг энэ норм ба дүрмийн 2.3 дахь хэсгээр зохицуулна.

2.1.7. Газрын нэгдмэл сангийн **ойн сан бүхий** ангилалын **газрын кадастрын зураглал үйлдэхдээ** ой мод, загтай газар, модыг нь огтолсон талбай, ойн цоорхой, зурвас, ойг өсгөн үржүүлэхэд зориулсан, ой тэлэн ургах боломжит газрын тогтоосон хил зааг, тэдгээрт байрлах объектуудад 2 буюу түүнээс дээш хэмжээсээр орон зайд гүйцэтгэнэ.

1. Ойн сан бүхий газарт кадастрын зураг үйлдэхдээ хамгаалалтын, ашиглалтын бүсийн тогтоосон солбицолоор ойн хил заагийг зураглана.

2. Ой бүхий газар, таримал ой, бут сөөг, мод бэлтгэсэн, ой, хээрийн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, ойн цоорхой, тарьц, суулгац бойжуулах мод үржүүлэг, түүнчлэн ойн захаас гадагш **100 метр** газрыг хамруулж хил заагийг тогтоож зураглана.

3. Ойн түймрийн хамгаалалтын зурвастай бол түүний хил заагийг зураглана.

4. Нийслэл, хот, тосгоны ногоон бүсэд хамаарах болон хориотой зурвасын ойн хил заагийг зураглана.

5. Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа ойн хил заагийг тогтоосон солбицолоор газар дээр тэмдэгжүүлж, кадастрын зураг гүйцэтгэж, мэдээллийн санд бүртгэнэ.

6. Ойн сан бүхий газар, түүний хамгаалалтын зурвас газар, нийслэл, хот, тосгоны ногоон бүсэд хамаарах болон хориотой зурвасын ойн хил заагийг тогтоосон солбицолоор газар дээр нь тэмдэгжүүлж, кадастрын зураг хийлгэж, улсын ойн мэдээллийн сан болон төрийн цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын мэдээллийн санд бүртгүүлсэн байна.

7. Ойн сан бүхий газар, түүний хамгаалалтын зурвас газар, нийслэл, хот, тосгоны ногоон бүсэд хамаарах болон хориотой зурвасын ойн хил заагийг тогтоосон солбицолоор газар дээр тэмдэгжүүлээгүй, кадастрын зураг хийлгээгүй, төрийн цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдээгүйгээс үүссэн хохирлыг түүнийг хариуцагч хариуцна.

8. Ойн сан бүхий газрын кадастрын зураглалыг хамгаалалтын, ашиглалтын бүсийн ой, ой модоор бүрхэгдсэн, бүрхэгдээгүй газрын ой, гадны нөлөөнд өртсөн ой гэсэн ангилалаар гүйцэтгэнэ

9. Ойн сан бүхий газрын кадастрын зураглал үйлдэхдээ 3 дугаар хүснэгтэд заасны дагуу үйлдэнэ.

3 дугаар хүснэгт

Ойн сан бүхий газрын кадастрын зураглал

Д.Д	Дэд ангилал	Кадастрын зураглалын давхрагийн нэр ашиглалтын зориулалт	Код /Lcode3/	Кадастрын зураглал үйлдэх арга зүй
1	Хамгаалалтын бүсийн ой	Цармын бүслүүрийн ой	1409	цармын бүслүүрийн ойн заагийг төрийн захиргааны төв байгууллага тогтоосон солбицолоор газар дээр бэхлэж тэмдэгжүүлж, кадастрын зураг үйлдэнэ.
2		тусгай хамгаалалттай газрын болон сургалт, судалгааны зориулалттай ой,	1410	Тусгай хамгаалалттай газрын ойн заагийг тогтоосон солбицолоор газар дээр бэхлэж тэмдэгжүүлж, кадастрын зураг үйлдэнэ.
3		ногоон бүс,	1411	Засгийн газрын тогтоолоор хил заагийг солбицолоор газар дээр бэхлэж тэмдэгжүүлж, кадастрын зураг үйлдэнэ.
4		хориотой зурвасын ой	1412	ойд нуур, рашаан, булаг, шандын ундаргын эргэн тойрон болон голын эргээс хоёр тийш 1000 метрийн доторх ой, улсын чанартай авто болон төмөр замын дагуу хоёр талын 100 метрийн доторх ой хамааруулж солбицолоор газар дээр бэхлэж тэмдэгжүүлж, кадастрын зураг үйлдэнэ.
5		заган ойгоор бүрхэгдсэн	4102	
6		Баян бүрдийн ой	1413	
7		100 га хүртэлх хэмжээний төгөл ой, бут, сөөг	1413	
8		30 хэмээс илүү налуу газрын ой	1314	
9	ашиглалтын бүсийн ой		1415	Ойн тухай хуулийн 8 дугаар зүйлд зааснаас бусад төрлийн ойг хамааруулж зураглана.
10	Ой модоор	ой модоор	4101	Ой тархан ургасан

	бүрхэгдсэн газар	бүрхэгдсэн		талбайг ойн сан бүхий газрын хил гэж үзэж нэгж талбарын кадастрын зураглал үйлдэнэ. Ойн сангийн кадастрын зураглал үйлдэхдээ энэхүү аргчлалын холбогдох заалтын дагуу хамгаалалтын зурвасыг татаж зураглана.
11		заган ойгоор бүрхэгдсэн	4102	
12		таримал ой	4103	
13		мод үржүүлгийн газар	4104	
14	Ой модоор бүрхэгдээгүй газар	модыг нь огтолсон талбай	4105	
15		ойн цоорхой	4106	
16		түймэрт өртсөн ой	4107	
17		ой тэлэн ургах нөөц газар	4108	
18	Гадны нөлөөнд өртсөн	Ямар нэг үйл ажиллагаанд өртсөн ой	1416	

2.1.8. Газрын нэгдмэл сангийн усны сан бүхий ангилалын газрын кадастрын зураглал үйлдэхдээ нуур, цөөрөм, тойром, гол, мөрөн, горхи, булаг, шанд, усан сан, рашаан, намаг, мөстөл, мөсөн голын эзэлж байгаа талбайгаар, тэдгээрийн хамгаалалтын зурвасын хамт үйлдэнэ.

1. Усны сан бүхий ангилалын газарт хамаарах объектуудад усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийг эргийн шугамаар болон эрх бүхий Засгийн газар, эрх бүхий Засаг даргын захирамжаар олгосон газрын эргэлтийн цэгээр тогтоосон хил заагийн шугамаас гадна тийш тооцож, эргэлтийн цэгийг тэмдэгжүүлсэн байна.

2. Гол, үерээс хамгаалах суваг, худаг, нуурын газарт голын эх ундарга, түүний урсацын гольдрол, үерээс хамгаалах зориулалтаар барьж байгуулсан далан суваг болон хамгаалалтын бүсийн хил заагийг солбицолоор газар дээр нь тэмдэгжүүлж кадастрын зураг үйлдэнэ.

3. Кадастрын зураглалд усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийг Усны тухай 22 дугаар зүйлийн 22.1, 22.2, 22.3 дахь заалтад заасан зай хэмжээгээр үйлдэнэ.

4. Кадастрын зураглалыг усан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс, ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн мужийн заагийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн тогтоосон солбицолоор газар дээр нь тэмдэгжүүлж, үйлдэнэ.

5. Кадастрын зураглалыг рашааны орд, эх булгийн эргэн тойронд эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг эх булгийн эргээс Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.10.1 дэх заалтад заасан зай хэмжээгээр үйлдэнэ.

6. Хамгаалалтын бүс нь хориглолт, хязгаарлалтын бүсээс бүрдэх бөгөөд кадастрын зураглалд хориглолтын бүсийг эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хил заагаас гадна тийш эргэн тойронд Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.10.2 дахь заалтад заасан зай хэмжээгээр зураглана.

7. Усны сан бүхий газрын кадастрын зураглал үйлдэхдээ 4 дүгээр хүснэгтэд заасны дагуу үйлдэнэ.

4 дүгээр хүснэгт

Усны сан бүхий газрын кадастрын зураглалын дэд ангилал,
давхрага, дугаар

	Ангилал		ашиглалтын зориулалт	Код /Lcode3/	Зураглал үйлдэх арга зүй
	Мөрөн, гол, горхи			5101	Усан сан газрын эрэг буюу усны түвшин хамгийн их байх үеийн хилийг усны сан бүхий газрын хил гэж үзэн нэгж талбарын кадастрын зураглал үйлдэнэ.
	Булаг, шанд			5102	
	Нуур, цөөрөм, тойром			5103	
	Мөнх цас, мөсөн гол			5104	
	рашааны орд, эх булгийн			5105	
	Устаж, ширгэсэн объект			5106	

2.1.9. Тусгай хэрэгцээний газрын кадастрын зураг үйлдэхдээ Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан 11 төрлөөр үйлдэнэ.

1. Улсын тусгай хамгаалалттай газар нутагт кадастрын зураглалыг түүний дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, дурсгалт газар гэсэн ангилал тус бүрээр Улсын их хурлын баталсан хил зааг, эргэлтийн цэгийн солбицолоор үйлдэнэ.

1.1. Дархан цаазат газрын кадастрын зураглалыг онгон, хамгаалалтын, хязгаарлалтын бүс тус бүрээр үйлдэнэ.

1.2. Байгалийн цогцолбор газрын кадастрын зураглалыг онцгой, аялал-жуулчлалын, хязгаарлалтын бүс тус бүрээр үйлдэнэ.

1.3. Байгалийн нөөц газрын кадастрын зураглалыг байгалийн байгалийн иж бүрдлийн нөөц, биологийн нөөц, түүхэн олдворын нөөц, геологийн нөөц, усны нөөц газар тус бүрээр үйлдэнэ.

1.4. Дурсгалт газрын кадастрын зураглалыг байгалийн, түүх соелын дурсгалт газар тус бүрээр үйлдэнэ.

1.5. Дурсгалт газрын кадастрын зураглалыг үйлдэхдээ Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2, 3 дугаар зүйлийг баримтлана.

1.6. Тусгай хамгаалалттай газар нутгийн кадастрын зураглалыг үйлдэхдээ түүний хил заагийг УИХ-аар батлагдсан солбицолыг баримтлана.

1.7. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн хил заагийн кадастрын зураглалыг үйлдэхдээ Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон солбицолын дагуу үйлдэнэ.

1.8. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглагчдын кадастрын зураг үйлдэхэд энэ норм ба дүрмийн 2.5 дахь хэсгийг баримтлана.

2. Улсын хилийн зурвас газрын кадастрын зураглалыг хилийн зурвас, боомтын газрын хамт үйлдэнэ.

2.1. Улсын хилийн зурвас газрын кадастрын зураглалыг улсын хилийн шугамаас дотогш 15 км-ээс илүүгүйгээр тусгай журам тогтоосон нутаг дэвсгэрээр үйлдэнэ.

2.2. Улсын хилийн зурвас газрын газрын, хот байгуулалтын, инженерийн ушугаман байгууламжийн болон бусад ангилалын кадастрын зураглалыг олон улсын гэрээнд заасны дагуу улсын хилийн шугам, хилийн тэмдгийн байршлыг хил залгаа улстай хамтран шалгах үед кадастрын зураглалын давхрагыг өөрчилж болно.

3. Улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газрын кадастрын зураглалыг тусгай зориулалтаар олгосон газарт Улсын Их хурлын тогтоолоор баталсан хилийн цэсийн солбицоор, хамгаалалтын зурвас газрын хамт үйлдэнэ.

Хүн амыг гамшигаас хамгаалах зориулалтаар хийгдэж байгаа кадастрын зураглал нь Улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газрын кадастрын зураглалын бүрэлдэхүүн хэсэг байна.

4. Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газрын кадастрын зураглалыг Улсын Их хурлын тогтоолоор баталсан хил заагийн эргэлтийн цэгийн солбицоор, хамгаалалтын зурвас газрын хамт үйлдэнэ.

5. Шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбайн газрын кадастрын зураглалыг Засгийн газрын тогоол, эрх бүхий Засаг даргын олгосон газрын баталсан хэмжээ хил заагийн солбицолоор үйлдэнэ.

6. Аймаг дундын отрын бэлчээрийн кадастрын зураглалыг Засгийн газрын тогоолоор баталсан хэмжээ хил заагийн солбицолоор үйлдэнэ.

7. Улсын тэжээлийн сангийн хадлангийн талбайн кадастрын зураглалыг Засгийн газрын тогоолоор баталсан хэмжээ хил заагийн солбицолоор үйлдэнэ.

8. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбайн кадастрын зураглалыг Засгийн газрын тогоолоор баталсан хэмжээ хил заагийн солбицолоор үйлдэнэ.

9. Чөлөөт бүсийн газрын кадастрын зураглалыг Улсын Их хурлын тогоолоор баталсан хэмжээ хил заагийн солбицолоор үйлдэнэ.

10. Цөмийн төхөөрөмж барих, ашиглах зориулалтаар олгосон газрын кадастрын зураглалыг Засгийн газрын тогоолоор баталсан хил заагийн солбицолоор үйлдэнэ.

11. Аймаг, нийслэл, сум, дүүргийн тусгай хамгаалалттай газар, дундын отрын бэлчээр, тэжээлийн сангийн хадлангийн талбайн кадастрын зураглалыг тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан талбайн хэмжээ, хил заагийн солбицолоор үйлдэнэ.

12. Бичил уурхайн зориулалтаар олгосон газрын кадастрын зураглалыг эрх бүхий этгээдийн олгосон хил заагийн солбицолоор үйлдэнэ.

13. Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар, аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих

газрын кадастрын зургийг Засгийн газрын тогтоол олгосон талбайн хэмжээ, хил заагийн солбицолоор үйлдэнэ

14. Улсын тусгай хэрэгцээний газарт газар ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын кадастрын зураглалд энэ норм ба дүрмийн 2.5-ыг баримтлана.

15. Улсын тусгай хэрэгцээний газарт инженерийн шугам байгууламжийн кадастрын зураглалыг үйлдэхдээ энэ норм ба дүрмийн 2.3-ыг баримтлана.

16. Улсын тусгай хэрэгцээний газарт ойн сан бүхий газрын кадастрын зураглал үйлдэхдээ энэ норм ба дүрмийн 2.1.7-г баримтлана.

17. Улсын тусгай хэрэгцээний газарт усан сан бүхий газрын кадастрын зураглалыг үйлдэхдээ энэ норм ба дүрмийн 2.1.8-ыг баримтлана.

18. Улсын тусгай хэрэгцээний газрын хил заагийн эргэлтийн цэгийн хэлбэрийг тусгайлан баталж болно.

19. Улсын тусгай хэрэгцээ бүхий газрын кадастрын зураглал үйлдэхдээ 5 дугаар хүснэгтэд заасны дагуу үйлдэнэ.

5 дугаар хүснэгт

Улсын тусгай хэрэгцээ бүхий газрын кадастрын зураглалын дэд ангилал, давхрага, дугаар

Д.Д	Ангиллын түвшин	Кадастрын зураглалын давхрагийн нэр /ашиглалтын зориулалтаар/	Код /Lcode3/	Кадастрын Зураглал үйлдэх арга зүй
1	Улсын тусгай хамгаалалттай газар	Дархан цаазат газар	6101	Их хурлын тогтоолоор баталсан хилийн цэсийн солбицолоор тухайн газрын кадастрын зургийг үйлдэж мэдээллийн санд оруулна.
		Байгалийн цогцолборт газар	6102	
		Байгалийн нөөцийн газар	6103	
		Дурсгалт газар	6104	
2	Улсын хилийн зурвас газар		6201	Монгол улсын Засгийн хоорондын хэлэлцээрээр тогтоож Улсын их хурлаар батлгаажсан багануудын солбицолоор хилийн шугамыг тогтооно. Хилийн хамгаалалтын зурваст газар олгосон болтүүнийг дүрмийн 11.2-ийн дагуу нэгж талбарын кадастрын зураглал үйлдэж мэдээллийн санд оруулна.

3	Улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар		6301	Улсын их хурлын тогтоолоор баталсан хилийн цэсийн солбицолоор тухайн газрын кадастрын зургийг үйлдэн бүртгэлхөтлөж мэдээллийн санд оруулна.
4	Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар		6401	Монгол Улсын Засгийн тогтоолоор баталсан хилийн цэсийн солбицолоор тухайн газрын кадастрын зураглал үйлдэх ба ашиглалтын зориулалтаар нь ангилж бүртгэл хөтлөж мэдээллийн санд оруулна.
5	Шинжлэх ухаан, технологийн сорилт туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай		6501	Улсын их хурлын тогтоолоор баталсан хилийн цэсийн солбицолоор тухайн газрын кадастрын зургийг үйлдэн бүртгэл хөтлөж мэдээллийн санд оруулна.
6	Аймаг дундын отрын бэлчээр		6601	Эрх зүйн харилцаа үүвсэн талбайг дүрмийн 11.2-ийн дагуу нэгж талбарын кадастрын зураглал үйлдэн бүртгэл хөтлөж мэдээллийн санд оруулна.
7	Улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай		6701	Эрх зүйн харилцаа үүвсэн талбайг дүрмийн 11.2-ийн дагуу нэгж талбарын кадастрын зураглал үйлдэн бүртгэл хөтлөж мэдээллийн санд оруулна.

8	Бүтээгдхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай		6801	Монгол улсын Засгийн тогтоолоор баталсан хилийн цэсийн солбицолоор тухайн газрын кадастрын зураглал үйлдэх ба ашиглалтын зориулалтаар нь ангилж бүртгэл хөтлөж мэдээллийн санд оруулна.
9	Чөлөөт бүсийн газар		6901	Улсын их хурлын тогтоолоор баталсан хилийн цэсийн солбицолоор тухайн газрын кадастрын зургийг үйлдэн бүртгэл хөтлөж мэдээллийн санд оруулна.
10	Цөмийн төхөөрөмж барих, ашиглах зориулалтаар олгосон		7001	Монгол улсын Засгийн тогтоолоор баталсан хилийн цэсийн солбицолоор тухайн газрын кадастрын зураглал үйлдэх
11	Бичил уурхайн зориулалтаар олгосон газар	нэнмсэн	7101	Эрх бүхий байгууллагын олгосон газрын эхил зааг ийн эргэлтийн цэгийн солбицолоор үйлдэнэ.
12	Орон нутгийн тусгай хэрэгцээний газар	нэмсэн	7201	кадастрын зураглалыг тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан талбайн хэмжээ, хил заагийн эргэлтийн цэгийн солбицолоор үйлдэнэ.

2.2. ХОТ БАЙГУУЛАЛТЫН КАДАСТРЫН ЗУРАГЛАЛ

2.2.1. Хот байгуулалтын кадастрын зураглалыг зам талбайн, ногоон байгууламжийн, барилга байгууламжийн, инженерийн шугам сүлжээний, гэр

холооллын, инженер геологийн, ус, ус сувгийн гэсэн дэд ангилалаар ялгаж үйлдэнэ.

2.2.2. Хот байгуулалтын кадастрын зураг нь 1:1000-ны масштабтай байна.

2.2.3. Хот байгуулалтын кадастрын зураглалыг үйлдэх газарт тухайн масштабын байр зүйн болон дэвсгэр зураг хийгдсэн бол түүнийг ашиглаж болно.

2.2.4. Хот байгуулалтын кадастрын зураглалыг үйлдэхэд агаар, сансрын зураг ашиглах бол 1:1000-ны масштабын зураг хийх нарийвчлалын шаардлага хангасан байна.

2.2.5. Барилга байгууламжийн кадастрын зураг үйлдэхэд барилгын дээвэр, үндсэн давхарын хэсэг, суурийн хэсэг болон гадна тохижилтын хэсэг (шат, пандус, хаяавч гэх мэт бусад хэсэг) тус бүрийг зураглана.

2.2.6. Барилгажсан талбайд кадастрын зураглал үйлдэхдээ барилга тус бүрийг зураглана.

2.2.7. Барилгажсан хэсгийн талбайг тооцоолохдоо үндэсэн давхрын талбай дээр гадна тохижилт (шаь фандус, хаяавч, дээврийн үндэсэн давхраас илүү гарсан хэсгийн талбай)-ын талбайг нэмж тооцно.

2.2.8. Консолийн талбайг үндсэн давхрын хэсэгт тооцож кадастрын зураглал үйлдэнэ.

2.2.9. Гэр хорооллын кадастрын зураглал үйлдэхдээ эзэмшиж, ашиглаж, өмчилсөн газарт хашаа барьсан бол хашаагаар, хашаа бариагүй бол хил заагийн эргэлтийн цэгээр зураглана.

2.2.10. Зам талбайн кадастрын зураглалд бусдын эзэмшил, ашиглалт, өмчлөсгөөс бусад авто зогсоол, гудамж талбай, явган хүний зам, явган хүний гүүрэн гарц, нүхэн гарц, дугуйн замыг 2 ба дүүнээс дээш хэмжээсээр үйлдэнэ.

2.2.11. Авто зогсоол гудамж талбайн кадастрын зураг үйлдэхдээ гэрлийн шонг хамт зурагласан байна.

2.2.12. Ногоон байгууламжийн кадастрын зургийг нийтийн эзэмшлийн, хязгаарлагдмал хэрэгцээний, тусгай зориулалтын гэж ангилан үйлдэнэ.

2.2.13. Инженер геологийн кадастрын зураглалыг

2.2.14. Усны кадастрын зураглалыг гүйцэтгэхэд энэ норм ба дүрмийн 2.1.8 дахь хэсгийг баримтлана.

2.2.15. Ус сувгийн кадастрын зураглалыг үйлдэхэд энэ норм ба дүрмийн 2.3 –ийг баримтлана.

2.2.16. Хот байгуулалтын кадастрын зураг үйлдэхэд Хот байгуулалтын мэдээллийн сангийн таних тэмдэг MNS 6736:2018 стандартыг мөрдөнө.

2.3. ИНЖЕНЕРИЙН ШУГАМАН БАЙГУУЛАМЖИЙН КАДАСТРЫН ЗУРАГЛАЛ

2.3.1. **Инженерийн шугаман байгууламжийн кадастрын зураглалыг газрын нэгдмэл сангийн ангилалыг харгалзан цахилгаан, дулаан, хий, ус хангамж, ариутгах татуурга, авто болон төмөр, усан зам, бүх төрлийн тээвэр, холбоо, мэдээллийн, иргэний нислэгийн аэродромын, түлш, эрчим хүчний, услалтын системийн бусад шугам сүлжээний гэсэн дэд ангилалаар ялгаж дэд бүтцийн байр зүйн агуулгатайгаар түүний онцгой ба энгийн хамгаалалт, эрүүл ахуйн бүсийн хамт газрын хэвлий, гадаргуу түүний хөрс, агаарын орон зайн давхаргад гүйцэтгэнэ.**

2.3.2. Инженерийн шугаман байгууламжийн кадастрын зураглалыг 1:1000-ны масштабаар үйлдэнэ.

2.3.3. Инженерийн шугаман байгууламжийн кадастрын зураглалыг үйлдэх газарт тухайн масштабын байр зүйн болон дэвсгэр зураг хийгдсэн бол түүнийг ашиглаж болно.

2.3.4. Инженерийн шугаман байгууламжийн кадастрын зураглалыг үйлдэхэд тухайн масштабын нарийвчлалын шаардлага хангах агаар, сансрын зураг ашиглаж гүйцэтгэж болно.

2.3.5. Инженерийн шугаман байгууламжийн кадастрын зураглалыг үйлдэхэд тухайн масштабын нарийвчлалын шаардлага хангахгүй, эсхүл байр зүй болон дэвсгэр, агаар, сансрын зураг, бүх төрлийн газрын зургийн масштабыг томруулж ашиглахыг хориглоно.

2.3.6. Инженерийн шугаман байгууламжийн кадастрын зураглалыг үйлдэхэд онцгой ба энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн хил заагийн солбицолыг тогтоосон иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолыг баримтлана.

2.3.7. Дулаан, усан хангамжийн шугам, түүний барилга байгууламжийн кадастрын зураглалыг дулаан, цэвэр ус дамжуулах, хуваарилах, хэрэглэгчид хүргэх зориулалт бүхий шугам сүлжээ, барилга байгууламж, тэдгээрийн хамгаалалтын бүсийн хил заагийг хамт үйлдэнэ. Усан хангамжийн шугамд ахуйн, үйлдвэрлэлийн ус түгээгүүрийн шугам, ус шахах худгууд, ус шахах, өргөх байгууламж, цэвэр, бохир усны худаг, дамжуулах хоолой, шугам, үерээс хамгаалах зориулалтаар барьж байгуулсан далан, суваг тэдгээрийг хамруулж гүйцэтгэнэ.

2.3.8. Төвлөрсөн усан хангамжийн унд, ахуйн ус түгээгүүрийн төв шугам хоолойн тэнхлэгээс хоёр **тийш 20 метрт** хамгаалалтын бүс тогтоож, хил заагийг зурагт үзүүлнэ. Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт заасны дагуу төвлөрсөн ус хангамжийн усны эх үүсвэрийн орчимд 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн халдвар хамгаалалтын бүсийн хил заагийг тогтоож кадастрын зураглалд үзүүлнэ.

2.3.9. Ариутгах татуургын шугамын кадастрын зураглалд ахуйн хэрэглээнээс гарсан бохир ус цуглуулах, татан зайлуулах, цэвэрлэх зориулалт бүхий шугам сүлжээ, барилга байгууламжийг хамруулж үйлдэнэ. Цэвэршүүлэх талбайн хил заагийг хашаагаар хашсан бол түүний гадна ирмэгээр, хашаагүй бол усан сангийн гаднах ирмэгээр зураглана. Энэхүү тодорхойлсон хилээс эрүүл ахуйн халдвар хамгаалалтын бүсийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг цэвэрлэх байгууламжийн хүчин чадалд үндэслэн тогтоосны дагуу зураглана.

2.3.10. Ариутгах татуургын эрүүл ахуйн бүсийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг 6 дугаар хүснэгтэд үзүүлсэн хэмжээгээр тогтоосгы дагуу зураглана.

6 дугаар хүснэгт

Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн зөвшөөрөх дээд хэмжээ

Д.Д	Бохир усны цэвэрлэх байгууламж	Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн зөвшөөрөх дээд хэмжээ /м-ээр/			
		Цэвэрлэх байгууламжийн хүчин чадал 1000 м.куб /хоног/			
		0.2 хүртэл	0.2-5.0	5.0-50.0	50.0-280.0
1	Лагийн талбайтай биологийн ба механик цэвэрлэх байгууламж	150	200	400	500

2	Лагийг халааж боловсруулах цэгтэй биологийн ба механик цэвэрлэх байгууламж, талбай	100	150	300	400
А.	Шүүх талбай	200	300	500	1000
Б.	Услах талбай	150	200	400	1000
В.	Биологийн цөөрөм	200	200	-	-

2.3.11. Цэвэрлэх байгууламжийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн зөвшөөрөх дээд хэмжээг цэвэрлэх байгууламжийн хүчин чадалд үндэслэн тогтоох ба эрүүл ахуйн бүсийг 7 дугаар хүснэгтэд үзүүлсэн хэмжээгээр тогтоосны дагуу зураглана.

7 дугаар хүснэгт

Цэвэрлэх байгууламжийн Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн зөвшөөрөгдөх хэмжээ

Д.Д	Цэвэрлэх байгууламжийн Хүчин чадал /м ³ /хоног/	Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ /м-ээр/
1	200 хүртэл	150
2	201-500	400
3	500-с дээш	500

2.3.12. Холбоо, мэдээллийн шугам, түүний барилга байгууламжийн кадастрын зураглал үйлдэхдээ газар дээрх тулгууртай шугам, газрын гадаргуу түүний хөрс, хэвлийд байрлах кабель, мэдээллийг хүлээн авах станцыг бодит байгаа хэмжээгээр нь болон хамгаалалтын бүсийг зураглана. Харилцаа холбооны тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу Агаарын баганат шугамын шугамын гадна утаснаас хоёр тийш 10 метр, кабелийн шугамын голоос хоёр тийш 5 метр, радио, телевизийн нэвтрүүлэх станцын тал бүрээс 300 метрээр хамгаалалтын зурвас тогтооно. Радиореле, телевизийн нэвтрүүлэх, дамжуулах байгууламжийн эрүүл ахуйн бүс нь 500 метр байна.

2.3.13. Шатахууныг хүлээн авах, хадгалах, тээврийн хэрэгслийг шатахуунаар цэнэглэх, хэрэглэгчдэд жижиглэн худалдаалах зориулалттай барилга байгууламжийн цогцолбор, орох гарах зам, технологийн худгууд, шатахуун нөөцлөх сав бүхий шатахуун түгээх станцын аюулгүйн бүс 100 м байна.

2.3.14. Зам, шугам сүлжээний газрын кадастрын зураглал үйлдэхэд хот, тосгон, бусад суурины гадна олгогдсон олон улс, улсын чанартай болон орон нутгийн чанартай авто замын зорчих хэсэг түүний ус зайлуулах сувгийн гадна ирмэгийн газрын өргөнөөр тооцсон газрыг хамааруулах ба түүний тэнхлэгийг геодезийн хэмжилтийн аргаар кадастрын зургийн нарийвчлал хангахаар хэмжиж түүнээс тооцсон өргөнөөр, зурвас газрын хамт зураглана.

2.3.15. Авто замын зурвас газрын өргөн олон улс, улсын чанартай замд 100 метр, орон нутгийн чанартай авто замд 60 метр байна.

2.3.16. Орон нутгийн чанартай авто замд төв, суурин газар болон үл хөдлөх эд хөрөнгөнд хүрэх замыг хамруулна. Тухайн авто замын байгууламжийн болон газар нутгийн онцлогоос шалтгаалан олон улс, улсын чанартай замын хяналт

тавих зурвас газрын өргөнийг, авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутаг, аж ахуйн нэгжийн дотоодын авто замын хяналт тавих зурвасын өргөнийг аймаг, нийслэлийн Засаг дарга тогтоотоосон зай хэмжээгээр зураглана.

2.3.17. Төмөр зам, шороон далан түүний хамгаалалтын болон аюулгүй бүсийг зохих хууль тогтоомжинд заасан хэмжээгээр зурагт оруулна. Улаанбаатар төмөр зам компаний эзэмшил төмөр замын хамгаалалтын бүс нь өртөө хоорондын замд 120 метр, өртөөний хязгаарт 300 метрийн өргөнтэй байна. Төмөр замын аюулгүйн бүс нь төмөр замын гол шугамаас хоёр тийш 500 метрийн өргөнтэй байна. Улаанбаатар төмөр зам компаний эзэмшилийн бус төмөр замын хамгаалалтын бүс нь өртөө хоорондын замд 100 метр, элсний нүүдэлтэй газарт хамгаалалтын зурвас газрын өргөнийг замын хоёр талд 500 м-ээс багагүй өргөнтэй байна.

2.3.18. Төмөр замын зурвас газрын хэмжээ, аюулгүйн бүсийн дэглэмийг хот байгуулалт, төмөр замын тээврийн аюулгүй байдлын нөхцөл шаардлагыг харгалзан Засгийн газрын тогтоосон хэмжээгээр үйлдэнэ. Зурвас газрын хэмжээг далангийн дээд ирмэгээс тооцно.

2.3.19. Аэродромын кадастрын зургийг агаарын хөлгийг байрлуулах, хөөргөх, буулгах, явгалахад зориулж тусгайлан тоногдсон газар болон усан гадаргуу түүний орчмын аюулгүйн бүс болох аэродромыг байгуулахдаа нислэгийн аюулгүй ажиллагааг хангах зайлшгүй шаардлагыг үндэслэн тогтоосон тодорхой хэмжээний хуурай газар, усан гадаргуу, орон зайн үзүүлэлтээр үйлдэнэ.

2.3.20. Кадастрын зурагт аэродром орчмын аюулгүйн бүсийг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага харъяалах сум, дүүргийн Засаг даргатай хамтарч баталсан саолбицолоор хил заагийг тогтооно.

2.3.21. Цахилгаан дамжуулах шугамын кадастрын зураглал үйлдэхдээ түүний байрлалыг геодезийн хэмжилтийн аргаар тухайн масштабын кадастрын зургийн нарийвчлал хангахаар хэмжиж цахилгаан дамжуулах шугам, түүний барилга, байгууламжийн хэрэглэгчдэд хүрэх хүртэл газарт агаар, газар доор, хэвлийд байрлах хамгаалалтын зурвас, аюулгүй бүсийн өргөнөөр үйлдэнэ.

2.3.22. Цахилгаан дамжуулах шугамын кадастрын зураглал үйлдэхдээ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, тосгон, чөлөөт бүсийн захирагчийн шугам сүлжээг хамгаалах дүрмийн дагуу тогтоосон хамгаалалтын зурвасын хэмжээ, байрлалыг батлагдсан солбицолоор хил заагийг тогтоож үйлдэнэ.

2.3.23. Эрчим хүчний хамгаалалтын зурвас газрыг бүх төрлийн бүх ангилалын кадастрын зураглалд үйлдэхдээ Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолоор баталсан Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрмийн дагуу тогтооно.

2.3.24. Кадастрын зураглал үйлдэхдээ эрчим хүчний хамгаалалтын зурвас газрыг дэд станцад станцын суурийн төвөөс, шугамд цахилгааны утасны гадна талаас тооцож хамгаалалтын зурвасын хил заагийг тогтооно.

2.3.25. Холбоо, мэдээллийн шугам, түүний барилга байгууламжийн кадастрын зураглал үйлдэхдээ харилцаа холбооны мэдээлэл нэвтрүүлэх, дамжуулах, хүлээн авах зорилгоор байгуулсан аливаа дамжуулагч орчин /утас, орон зай зэрэг/ тэдгээрийг хамгаалахад хэрэглэдэг тусгаарлагч, сувагчлал, багана, цамхаг байгуулсан, хамгаалалтын зурвасын хамт үйлдэнэ.

2.3.26. Харилцаа холбооны хамгаалалтын зурвас газрыг Харилцаа холбооны тухай хуулийн 28 дугаар зүйлээр зохицуулна.

2.3.27. Усан хангамжийн байгууламжид дулаан дамжуулах, цэвэр усны, ариутгах татуургын шугамыг тэдгээрт хамаарах худаг, хамгаалалтын бүсийн хамт үйлдэнэ.

2.3.28. Услалтын системийн кадастрын зураг нь услалтын болон халаалтын системийн гэсэн 2 хэсэгтэй байна.

1. Услалтын системийн кадастрын зураглалыг хиймэл нуур, байгалийн хийгээд хиймэл усны эх үүсвэрт барьсан ус татамжийн, загас хамгаалах байгууламж, тунгаагуур, шахуургат станц, услалтын, ус цуглуулгын, ус хаюурын шүүрүүлийн сүлжээ, уулын суваг, сүлжээн дээрх барилга, бороожуулах машин, усалгааны тоног төхөөрөмж, усалгааны төлөв байдлын хяналт-удирдлагын, автоматжуулалтын багаж хэрэгсэл, цахилгаан хангалт, холбооны объект, хөрсний элэгдэлтэй тэмцэх зориулалт бүхий барилга, услалтын системийн ашиглалтын албаны зориулалттай үйлдвэрлэлийн болон орон сууцны барилга, зам, талбай хамгаалалтын ойн зурвас, далан багтаан үйлдэнэ.

2. Хатаалтын системийн кадастрын зураглалыг ус хүлээн авах байгууламжийн тохируулалттай хэсэг, ус зайлуулах, хаах, тохируулах сүлжээ, шахуургат станц, далан, сүлжээн дээрх байгууламж, хяналт-удирдлагын, автоматжуулалтын багаж хэрэгсэл, цахилгаан, холбооны объект, ашиглалтын албаны зориулалттай үйлдвэрлэлийн болон орон сууцны барилга, зам, талбай хамгаалалтын ойн зурвас, усны бусад байгууламжийг багтаан үйлдэнэ.

2.3.29. Услалтын системийн кадастрын зургаас бусад инженерийн шугаман байгууламжийн кадастрын зургийг үйлдэхэд Хот байгуулалтын мэдээллийн сангийн таних тэмдэг MNS 6736:2018-ыг баримтлана.

2.3.30. Услалтын системийн кадастрын зураглалыг дэд ангилалаар давхрага /Lcod/-д 8 дугаар хавсралтад заасны дагуу үйлдэнэ.

8 дугаар хавсралт

Услалтын системийн кадастрын зураглалын дэд ангилал,
давхрага, дугаар

Д.Д	Дэд ангилал	Кадастрын зураглалын давхрагийн нэр /ашиглалтын зориулалтаар/	Давхрагын дугаар /Lcod/	Кадастрын зураглал үйлдэх арга зүй
1	Услалтын систем	Хиймэл нуур		Хиймэл нуурын эзлэх талбайн хэмжээгээр зураглана.
2		Ус татамжийн		байгалийн хийгээд хиймэл усны эх үүсвэрт барьсан
3		Загас хамгаалах багууламж		
4		Тунгаагуур		
5		шахуургат станц		
6		услалтын		
7		ус цуглуулгын		Эзлэх талбайн

				хэмжээгээр зураглана
8		ус хаюурын шүүрүүлийн сүлжээ		
9		уулын суваг		
10		сүлжээн дээрх барилга		
11		бороожуулах машин		
12		усалгааны тоног төхөөрөмж		
13		усалгааны төлөв байдлын хяналт- удирдлагын багаж хэрэгсэл		
14		автоматжуулалтын багаж хэрэгсэл		
15		цахилгаан хангалт		
16		холбооны объект		
17		хөрсний элэгдэлтэй тэмцэх зориулалт бүхий барилга		
18		услалтын системийн ашиглалтын албаны зориулалттай үйлдвэрлэлийн болон орон сууцны барилга		
19		зам, талбай хамгаалалтын ойн зурвас		
20		далан		
21	Халаалтын систем	ус хүлээн авах байгууламжийн тохируулалттай хэсэ		Эзлэх талбайн хэмжээгээр зураглана
22		ус зайлуулах сүлжээ		
23		ус хаах сүлжээ,		
24		ус тохируулах сүлжээ		
25		шахуургат станц		
27		далан		
28		сүлжээн дээрх байгууламж		
29		хяналт-удирдлагын, автоматжуулалтын багаж хэрэгсэл		
30		Цахилгааны объект		
31		холбооны объект		
32		ашиглалтын албаны зориулалттай үйлдвэрлэлийн болон орон сууцны барилга		

33		ам, талбай хамгаалалтын ойн зурвас		
34		бусад		

2.4. ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН КАДАСТРЫН ЗУРАГЛАЛ

2.4.1. Геологи, уул уурхайн кадастрын зураглалыг газрын нэгдмэл сангийн ангилалд хамааруулж геологи, эрэл хайгуулын, уурхайн, нөөцөд авсан талбайн, уул уурхайн үйл ажиллагаанаас эвдэрсэн, нөхөн сэргээсэн газар гэсэн ангиллаар гүйцэтгэнэ.

2.3.31. Геологи, уул уурхайн кадастрын зураглалыг дэд ангилал, давхрага /Lcod/-д 9 дүгээр хавсралтад заасны дагуу үйлдэнэ.

9 дүгээр хавсралт

Услалтын системийн кадастрын зураглалын дэд ангилал, давхрага, дугаар

Д.Д	Дэд ангилал	Кадастрын зураглалын давхрагийн нэр /ашиглалтын зориулалтаар/	Давхра- гын дугаар /Lcod/	Кадастрын зураглал үйлдэх арга зүй
1	Геологи	Геологи		Геологийн хайгуул судалгаа хийгдсэн талбайд ашигт малтмалын төрлөөр
2		Эрэл хайгуулын		Эрэл хайгуул хийгдэж байгаа газрын талбайн хэмжээгээр зураглана.
3	Уул уурхайн	Уурхайн		Уул уурхайн тусгай зөвшөөрөл олгосон талбайгаар үйлдэнэ. /
4		Нөөцөд авсан талбайн		Хайгуулын нөөц тогтоосон талбайгаар үйлдэнэ.
5		Уул уурхайн үйл ажиллагаанаас эвдэрсэн газар		Уул уурхайн үйл ажиллагаанаас үүссэн эвдэрсэн газрын хэмжээгээр үйлдэнэ.
6		Уул уурхайн үйл ажиллагаанаас нөхөн сэргээсэн газар		Уул уурхайн үйл ажиллагаанаас үүссэн эвлэрсэн газрыг нөхөн сэргээж улсад

				актаар хүлээлгэн өгсөн талбайн хэмжээгээр үйлдэнэ.
--	--	--	--	--

2.5. БУСАД /ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ХОЛБОГДОХ ХУУЛИЙН ДАГУУ ЭРХ ҮҮССЭН ГАЗРЫН КАДАСТРЫН ЗУРАГЛАЛ/

2.5.1. Газрын нэгдмэл сангийн ангилалаас хамаарахгүйгээр газар эзэмших, ашиглах, өмчлөх шийдвэр гарсан иргэн, хуулийн этгээдэд газар зохион байгуулалт хариуцсан байгууллагын хариуцсан газар зохион байгуулагч газрын хил зааг, эргэлтийн цэгийг газарт бэхлэх, тэмдэгжүүлэх мэдэгдлийг Е хавсралтын дагуу бичнэ.

2.5.2. Геодези, зураг зүйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж нь иргэн, хуулийн этгээдийн эзэмших, ашиглах, өмчлөх газарт Е хавсралтад заагдсан солбицолоор хил зааг, эргэлтийн цэгийг хэмжиж тодорхойлж, эргэлтийн цэгийг газар дээр бэхлэж, тэмдэгжүүлж, Ж хавсралтаар хүлээлгэн өгч, З хавсралтаар кадастрын зураг гүйцэтгэж хэвлэж баталгаажуулна.

2.5.3. Энэ норм ба дүрмийн 1.3.10 дахь хэсгийн бүрдэл хангасан кадастрын зургийг мэдэгдэл бичсэн газар зохион байгуулагч хүлээн авч, хянаж гарын үсэг зурж Төрийн цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын мэдээллийн санд бүртгэнэ.

2.5.4. Эрхийн харилцаа үүссэн газрын эргэлтийн цэгийг газарт бэхлэх, тэмдэгжүүлэх мэдэгдэл, кадастрын зургийн солбицолтой тулгаж, нарийвчлалын шаардлага хангасан эсэхийг хянаж, эргэлтийн цэг газарт тэмдэгжүүлэн хүлээлгэн өгсөн актыг газар зохион байгуулагч гарын үсэг зурж баталгаажуулж, төрийн цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын мэдээллийн санд бүртгэнэ.

2.5.5. Эрхийн харилцаа үүссэн газрын кадастрын зургийн солбицолоор төрийн цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын мэдээллийн санд бүртгэж нэгж талбарын дугаар олгож, нэгж талбарын кадастрын зургийг Ж хавсралтаар 2 хувь хэвлэн, баталгаажуулж, 1 хувийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад, 1 хувийг энэ норм ба дүрмийн 1.3.10 дахь хэсэгт заасан бүрдэлийн хамт эх хувиар нэгж талбарын хувийн хэрэгт хадгална.

2.5.6. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр нэгж талбарын кадастрын зурагт орсон өөрчлөлтийг үндэслэн төрийн цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулж болно.

2.5.7. Эргэлтийн цэгийг газарт тэмдэгжүүлэн бэхэлсэн кадастрын зураг нь бүрдэл хангаагүй бол төрийн цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын мэдээллийн санд бүртгэхийг хориглоно.

2.5.8. Улсын тусгай хэрэгцээний газрын болон газар эзэмших, ашиглах эрхийн харилцаа үүссэн кадастрын зураглалыг хил заагийг солбицолоор газар дээр хэмжиж тодорхойлон эргэлтийн цэгийг бэхлэхгүйгээр үйлдэхийг хориглоно.

2.5.9. Бүх төрлийн бүх ангилалын газарт газрын хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэг гэмтсэн устсан бол түүнийг газар дээр нь тодруулах, устсан бол хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийг сэргээх, тодруулах хэмжилт хийлгэж болно.

2.5.10. Бүх төрлийн бүх ангилалын газарт газрын хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийг сэргээн тодруулах хэмжилтэд энэ норм ба дүрмийн 7 дахь хэсгийг дагаж мөрдөнө.

2.5.11. Иргэн, хуулийн этгээдийн эзэмшиж, ашиглаж, өмчлөж байгаа газар, түүний гадаргуу, агаар, хэвлийд буюу газар доор баригдасан барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээ болон бусад объект, эд зүйлийн хил зааг, тэдгээрийн эргэлтийн цэгийг тогтоох хэмжилт хийлгэж болно.

2.5.12. Хэмжилт хийсэн аж ахуйн нэгж нь хэмжилт хийж, кадастрын зураг үйлдэж, тэмдэглэлийг хавсралт К хавсралт үйлдэж, ямар нэг дүгнэлт, шийдвэр гаргахыг хориглоно.

2.5.13. Кадастрын зураглалын хэмжилтийн боловсруулалтад энэ норм ба дүрмийн 7 дахь хэсгийг мөрдөнө.

2.5.14. Газрын тухай хуулийн 60 дугаар зүйлд заасан газартай холбогдон үүссэн маргааныг хянан шийдвэрлэхдээ байгууллага, аж ахуйн нэгж, иргэний эзэмших, ашиглах, өмчлөх газрын нэгж талбарын кадастрын зураг болон газар, түүний гадаргуу, агаар, хэвлийд буюу газар доор баригдасан барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээ болон бусад объект, эд зүйлийн хил зааг, тэдгээрийн эргэлтийн цэгийг тогтоохоор хийсэн хэмжилт, магадлан хэмжилтийн кадастрын зургийг баримтлана.

2.5.15. Газар зохион байгуулалтыг хариуцсан байгууллагаас энэ норм ба дүрмийн 2.5.9-ийн дагуу газар дээр нь үзлэг хийж хөршүүдтэй хийсэн тэмдэглэл үйлдэнэ. (2008 оны 83 дугаар тушаалын 4 хавсралт)

2.5.16. Газартай холбогдон үүссэн маргааныг хянан шийдвэрлэхдээ тухайн цаг хугацаанд хийсэн масштаб, нарийвчлал хангах байр зүйн болон дэвсгэр, агаар сансрын зураг ашиглаж болно.

2.5.17. Иргэн, хуулийн этгээдийн газар, эзэмших, ашиглах, өмчлөх хүсэлт гаргах зориулалтаар эрхийн харилцаа үүсээгүй үед хийлгэсэн кадастрын зураг нь тухайн газрыг төрийн цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын мэдээллийн санд бүртгэх үндэслэл болохгүй.

2.5.18. Газар, түүний хэвлий буюу доор баригдсан барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээ болон бусад объект, эд зүйлсийн хил зааг, тэдгээрийн эргэлтийн цэгт 2 аж ахуйн нэгжийн гүйцэтгэсэн хэмжилт зөвшөөрөгдөх хэмжээнээс их бол 3 дахь хэмжилтийг заавал гүйцэтгэнэ.

ГУРАВ. КАДАСТРЫН ЗУРАГЛАЛЫН, БАЙРЛАЛ ӨНДРИЙН СОЛБИЦОЛЫН ТОГТОЛЦОО, МАСШТАБ, НАРИЙВЧЛАЛ /АНГИЛАЛ ТУС БҮРЭЭР/

3.1. Кадастрын зураглалын байрлал, өндрийн солбицолын тогтолцоо:

3.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд бүх ангилалын бүх төрлийн кадастрын зураглал үйлдэхдээ энэ норм ба дүрмийн 3.1-ийг баримтлана.

3.1.2. Кадастрын зураглалыг солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд тухайн хэмжилт хийж буй газарт нарийвчлалын шаардлага хангах хамгийн ойр орших геодезийн сүлжээний байнгын цэгээс үйлдэнэ.

3.2. Кадастрын зураглалын масштаб:

3.2. Жимс жимсгэнэ, ногооны талбай, тариалан, хадлангийн талбай, бэлчээр, ой, усан сан, геологи, уул уурхайн талбайд хийгдэх кадастрын зураг нь Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.2 дахь заалтад заасан масштабтай байна.

3.2.2. Хот, тосгон, бусад суурин газарт бүх ангилалын бүх төрлийн кадастрын зураг нь 1:1000-ны масштабтай байна.

3.2.3. Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.2, энэ норм ба дүрмийн 3.2.2-т тусгаснаас бусад газрын кадастрын зураг нь 1:5000-аас багагүй байна.

3.3. Кадастрын зураглалын нарийвчлал:

3.3.1. Бүх ангилалын, бүх төрлийн кадастрын зураглал нь байрлалын хувьд Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг /масштабын 0.1 мм-т ногдох хэмжээ/-т зааснаас хэтрэхгүй байна.

3.3.2. Хот, тосгон, бусад суурин газрын бүх ангилалын бүх төрлийн газарт кадастрын зураг нь өндрийн хувьд нь 0.3 м-ээс ихгүй нарийвчлалтай байна.

3.3.3. Хот, тосгон, бусад суурин газраас бусад бүх ангилалын бүх төрлийн газарт гүйцэтгэх 1:5000-аас том масштабтай кадастрын зураг нь өндрийн хувьд нь 1:500, 1:1000, 1:2000, 1:5000-ны масштабтай байр зүйн дэвсгэр зураглалын ажил БД 11-106-08-ын 7.2-т заасан хэмжээнээс ихгүй байна.

3.3.4. Жимс жимсгэнэ, ногооны талбайн 1:2000-ны масштабтай кадастрын зураг нь өндрийн хувьд нь 0.3 м-ээс ихгүй нарийвчлалтай байна.

3.3.6. 1:25000, 1:50000, 1:10000 -аас багагүй масштабтай үйлдэгдэж байгаа кадастрын зургийн өндрийн алдаа нь байр зүйн зурагт гарах алдааны хэмжээтэй ижил байна.

3.4.6. 1:25000, 1:50000, 1:10000 -аас багагүй масштабтай үйлдэгдэж байгаа кадастрын зургийн өндрийн алдаа нь байр зүйн зургийн үеийн өндрийн 3/1-ээс хэтрэхгүй байна.

ДӨРӨВ. КАДАСТРЫН ЗУРАГЛАЛЫН АЖЛЫГ ТӨЛӨВЛӨХ, ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ЖАГСААЛТ

4.1. Кадастрын зураглалын ажлыг төлөвлөх.

4.1.1. Бүх ангилалын бүх төрлийн кадастрын зураглалыг үйлдэхдээ захиалагчийн ажлын даалгавар, талбайтай танилцаж, шинээр гүйцэтгэх кадастрын зураглал үйлдэх хил заагийг /хилийн шугам/-ыг урьдчилан судалж тогтооно. 10 га газраас бага талбайн кадастрын зураглалыг ажлын даалгаваргүй гүйцэтгэж болно.

4.1.2. Бүх ангилалын бүх төрлийн кадастрын зураглал үйлдэх талбайн хил заагийг тодорхойлж түүнд хамгийн ойр байрлах геодезийн байрлал, өндрийн сүлжээний байнгын цэгүүдийн судалгаа хийж, нэмэлт байрлал, өндрийн сүлжээний цэг байгуулах шаардлагатай бол байгуулах цэгийн тоо, байрлалыг урьдчилан тогтоож, шинээр суулгах цэг, тэмдэгтийн төрлийг сонгоно.

4.1.3. Бүх ангилалын бүх төрлийн кадастрын зураглал үйлдэх ажлыг хот, тосгон, бусад суурин газарт төлөвлөхдөө GNSS-ийн суурин станц болон геодезийн сүлжээний байнгын цэгийн тоон мэдээллийг геодези, зураг зүйн улсын нэгдсэн сангаас авна.

4.1.4. Бүх ангилалын бүх төрлийн кадастрын зураглал үйлдэх ажлыг хот, тосгон, бусад суурин газрын гадна төлөвлөхдөө зураглал хийх талбайд өмнө байгуулсан геодезийн байрлал, өндрийн сүлжээний цэгийн судалгааг хийж, цэг устсан эсэхийг тодруулах, тухайн цэг болон зураглал үйлдэх талбайн ойролцоо

байрлах цэгийн тоон мэдээллийг геодези, зураг зүйн улсын нэгдсэн мэдээллийн сангаас авна.

4.1.5. Бүх ангилалын бүх төрлийн кадастрын зураглал үйлдэх талбайд болон ойролцоо байрлах геодезийн байрлал, өндрийн сүлжээний цэг устсан, хэмжилтийн нарийвчлалын шаардлага хангах цэг байхгүй, эсхүл хэмжилтийн нарийвчлалын шаардлагад нийцүүлж шинээр геодезийн байрлал, өндрийн сүлжээний цэг байгуулах бол зураглалын сүлжээ шинээр байгуулахаар төлөвлөж, төрлийг сонгоно.

4.1.6. Кадастрын зураглал үйлдэх ажлыг төлөвлөхөд 1:500, 1:1000, 1:2000, 1:5000-ны масштабтай байр зүйн дэвсгэр зураглалын ажил БД 11-106-08-ын 8, 9 дэх хэсгүүдийг баримтлан гүйцэтгэнэ.

4.1.7. Кадастрын зураглалын үйлдэхэд байрлал, өндрийн сүлжээний цэгийн судалгаа хийх, сэргээх, зураглалын цэг шинээр байгуулах, суулгах ажлыг төлөвлөхдөө Геодезийн байнгын цэг тэмдэгт байгуулах ажил БД 11-104-19-ийг баримтлана.

4.1.8. Кадастрын зураглалын үйлдэх зураглалын цэг шинээр суулгаж байрлал, өндрийн хэмжилт боловсруулалт хийх ажлыг төлөвлөхдөө 1:500, 1:1000, 1:2000, 1:5000-ны масштабтай байр зүйн дэвсгэр зураглалын ажил БД 11-106-08-ын 11, 12,13,14,15,16,17,18 дахь хэсгүүдийг баримтлана.

4.1.9. Бүх ангилалын бүх төрлийн кадастрын зураглал үйлдэх төсөл, даалгаварт солбицол, өндрийг тодорхойлох хэмжилт, боловсруулалт хийх нарийвчлал, газар дээр солбицолыг хэмжиж тогтоох дарааллыг тусгасан байна.

4.2. Кадастрын зураглалын үе шатны ажлын жагсаалт.

4.2.1. Геодезийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж нь захиалагч болох иргэн, хуулийн этгээдээс кадастрын зураглал үйлдэх захиалгыг хүлээн авч, батлагдсан техникийн төсөл, даалгавартай танилцана.

4.2.2. Кадастрын зураглал үйлдэхэд ашиглах геодезийн байрлал, өндрийн сүлжээнд суурин судалгаа хийж, шинээр суулгах зураглалын цэгийг төлөвлөж, хэмжилт хийх цэгүүдийн тоон өгөгдлийг геодези, зураг зүйн улсын нэгдсэн сангаас авна.

4.2.3. Кадастрын зураглал үйлдэх газрын орчим байрлах геодезийн сүлжээний цэгүүдийн судалгаа, шинээр зураглалын сүлжээ байгуулах, суулгах цэгийн хайгуул хийж, байрлалыг тогтоох.

4.2.4. Зураглалын сүлжээний цэгийн төв бэлтгэж, газарт суулгах,

4.2.5. Шинээр байгуулсан зураглалын сүлжээний цэгт байрлал, өндөр тодорхойлох хэмжилт, боловсруулалт хийх,

4.2.6. Кадастрын зураглалын хэмжилт хийнэ.

4.2.7. Эрхийн харилцаа үүсээгүй эзэмших, ашиглах, өмчлэх хүсэлт гаргах газарт кадастрын зураглалын хэмжилт, боловсруулалт хийж, хүлээлгэн өгнө.

4.2.8. Эрхийн харилцаа үүссэн газарт нэгж талбарын хил заагийн эргэлтийн цэгийг газарт тэмдэгжүүлэх мэдэгдэлд тэмдэглэгдсэн солбицолын дагуу газар дээр нь хэмжилт хийж, эргэлтийн цэгийг байрлал, өндрөөр олж, эргэлтийн цэгийг газарт тэмдэгжүүлж, хүлээлгэн өгсөн акт үйлдэнэ.

4.2.9. Эргэлтийн цэг, хил заагт кадастрын зураглалын хэмжилт хийх,

4.2.10. Кадастрын зураглалын боловсруулалт хийх,

4.2.11. Кадастрын зургийг баталгаажуулж захиалагчид хүлээлгэн өгөх.

ТАВ. КАДАСТРЫН ЗУРАГЛАЛЫН БАЙРЛАЛ, ӨНДРИЙН ҮНДЭСЛЭЛИЙН СҮЛЖЭЭ БАЙГУУЛАХ

1.1. Бүх төрлийн бүх ангилалын кадастрын зураглалын хэмжилт хийх зураглалын цэг шинээр байгуулах бол батлагдсан төсөл, даалгаврын дагуу гүйцэтгэнэ.

1.2. Кадастрын зураглал хийх талбайд зураглалын сүлжээний цэг шинээр байгуулах бол “1:500, 1:1000, 1:2000, 1:5000 масштабтай байр зүйн зураглалын ажил” БД 11-106-08-ын 9.9, 9.10 дах хэсэгт заасныг баримтлан зураглалын сүлжээ байгуулна.

1.3. Бүх ангилалын бүх төрлийн кадастрын зураглал хийх талбайд геодезийн байрлал, өндрийн сүлжээний цэгийн судалгаа хийх, шинээр суулгахаар төлөвлөсөн зураглалын цэгийг газар дээр нь судалгаа хийж, байгуулахад **Геодезийн сүлжээний байнгын цэг тэмдэгт байгуулах ажил** БД 11-104-19 -ийг баримтлана.

1.4. Бүх ангилалын бүх төрлийн кадастрын зураглал хийх талбайд шинээр байгуулах зураглалын цэгийн төвийг урьдчилсан байдлаар бэлтгэсэний дараа газарт бэхэлж, суулгана.

1.5. Зураглалын цэгт байрлал тодорхойлох хэмжилтийг “Хиймэл дагуул (GPS/Глонасс)-ын технологиор Монгол Улсын геодезийн сүлжээ байгуулах үндсэн дүрэм” БНБД 14-101-08-ын 2.5-ыг баримтлана.

1.6. Зураглалын сүлжээний цэгийн өндрийг нивелирдлэгийн IY ангийн нарийвчлалтайгаар тодорхойлох ба GPS-ын технологи ашиглан тодорхойлсон бол эллипсоидын өндрийг эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн боловсруулалтын программ хангамжаар ортометрийн өндөрт шилжүүлэн тодорхойлж болно.

1.7. Бүх ангилалын бүх төрлийн дунд масштабын кадастрын зураглал үйлдэхдээ 1:10000, 1:25000, 1:50000, 1:100000-ны масштабтай байр зүйн зураглал үйлдэх норм, дүрэм, стандартыг баримтлана.

1.8. Улсын болон орон нутгийн төсөв, гадаад, дотоодын зээл тусламж, хандивын хөрөнгөөр гүйцэтгэсэн бүх ангилалын бүх төрлийн кадастрын зураглал үйлдэхэд шинээр байгуулсан зураглалын сүлжээний цэгүүдийг төрийн хамгаалалтад Геодези, зураг зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийнгт заасан 10.2 дахь хэсэг, **Геодезийн сүлжээний байнгын цэг тэмдэгт байгуулах ажил** БД 11-104-19–ийг баримтлан төрийн хамгаалалтад хүлээлгэн өгнө.

1.9. Улсын болон орон нутгийн төсөв, гадаад, дотоодын зээл тусламж, хандивын хөрөнгөөр бүх ангилалын бүх төрлийн кадастрын зураглал үйлдсэн бол тайланд геодезийн сүлжээний цэгийн хайгуул судалгаа, шинээр суулгасан зураглалын цэг, түүнд хийсэн байрлал, өндрийн хэмжил, боловсруулалтын үр дүнгийн талаар дэлгэрэнгүй тусгасан байна.

ЗУРГАА. ГАЗАР АШИГЛАЛТЫН ТӨРӨЛД ХАМРАГДАЖ БУЙ газрын хэвлий буюу газар доорх болон АГААРЫН ХИЛ, СТАНДАРТ ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ

6.1. Бүх төрлийн бүх ангилалын төрийн цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын мэдээллийн санд бүргэгдэж, хэвлэгдсэн кадастрын зургийн солбицолоор тогтоосон хил зааг, эргэлтийн цэгийг газрын хэвлийд буюу газар дор, агаарын зай хэмжээгээр тогтооно.

6.2. Иргэн, хуулийн этгээдийн эзэмшиж, ашигдаж, өмчилж байгаа газарт баригдсан барилга, байгууламжид хэмжилт хийхэд газрын хил зааг, эргэлтийн цэг устаагүй хамгаалагдсан байна.

6.3. Газар ашиглалтын төрөлд хамрагдаж буй газрын хэвлий буюу газар доорх болон агаарын хил, стандарт түвшинг тодорхойлоход эзэмшиж, ашиглаж,

өмчилж байгаа газрын хил зааг, эргэлтийн цэг устсан, гэмжтсэн бол цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын мэдээллийн санд бүргэгдэж, хэвлэгдсэн кадастрын зургийн солбицолоор шалгалтын хэмжилт хийж, тодруулна.

6.4. Эзэмшиж, ашиглаж өмчилсөн газрын хил зааг эргэлтийн цэг нь тодорхой бол баригдсан барилгын үндсэн давхар /консоль, балконы хэсэг орсон/ -ын хэсгээр шууд хэмжилт хийж тодорхойлж болно.

ДОЛОО. НЭГЖ ТАЛБАР ҮҮСЭХ ГАЗРЫН ХИЛ, ЗААГ, ТЭДГЭЭРИЙН ЭРГЭЛТИЙН ЦЭГИЙГ ТОГТООХ ГЕОДЕЗИЙН ХЭМЖИЛТ, БОЛОВСРУУЛАЛТ ХИЙХ АРГАЧЛАЛ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

7.1. Нэгж талбар үүсэх газрын хил, зааг, тэдгээрийн эргэлтийн цэгийг геодезийн хэмжилтээр газар дээр нь тогтооход дараах шаардлагыг хангасан байна.

7.1.1. Эзэмших, ашиглах, өмчлөх газарт эрх бүхий Засаг дарга, Чөлөөт бүсийн захирагчийн захирамж, тусгай хамгаалалттай газар нутагт Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр гарсан байна.

7.1.2. Улсын тусгай хэрэгцээний газарт УИХ, Засгийн газрын тогтоол болон аймаг, нийслэл сум, дүүргийн орон нутгийн хэрэгцээнд авсан тухай тогтоол гарсан байна.

7.1.3. Газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхийн харилцаа үүссэн газарт аймаг, нийслэл, дүүргийн газрын асуудал эрхэлсэн алба, чөлөөт бүсийн, тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны газар зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн, сумд /хотхон/-ын газрын даамлаас “Нэгж талбар үүсэх газрын хил, зааг, тэдгээрийн эргэлтийн цэгийг газарт бэхлэх, тэмдэгжүүлэх” мэдэгдэл бичсэн байна.

7.1.4. “Нэгж талбар үүсэх газрын хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийг газарт бэхлэх, тэмдэгжүүлэх” мэдэгдлийг газрын зориулалтаас хамаарахгүй шинээр эрхийн харилцаа үүсэж байгаа бүх төрлийн бүх ангилалын газарт бичнэ.

7.1.5. Нэгж талбар үүсэх газрын хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийг газарт бэхлэх, тэмдэгжүүлэх мэдэгдэл хүлээн авч энэ норм ба дүрмийн 1.3 дахь хэсгийн 15-ын шаардлага хангасан иргэн, аж ахуйн нэгжид хандана.

7.2. Нэгж талбар үүсэх газрын хил, зааг, тэдгээрийн эргэлтийн цэгийг тогтоох геодезийн хэмжилт үйлдэхэд тавигдах шаардлага.

7.2.1. Газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгчөөс “Нэгж талбар үүсэх газрын хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийг газарт бэхлэх, тэмдэгжүүлэх” мэдэгдэл хүлээн авсан иргэн, аж ахуйн нэгж нь хээрийн хэмжилт хийх бэлтгэл ажлыг хангасан байна.

7.2.2. Эзэмших, ашиглах, өмчлөх газрын хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийг газарт бэхлэх, тэмдэгжүүлэх” мэдэгдэлд бичигдсэн солбицолоор газрын байрлалыг байр зүйн болон дэвсгэр, агаар, сансрын зураг ашиглан урьдчилан тогтооно.

7.2.3. “Эзэмших, ашиглах, өмчлөх газрын хил, зааг, тэдгээрийн эргэлтийн цэгийг газарт бэхлэх, тэмдэгжүүлэх” мэдэгдэлд бичигдсэн газрын нэгдмэл сангийн ангилалд хамаарах төрлөөс хамааруулж масштаыг энэ норм ба дүрмийн 1.3 дахь хэсгийн 12-т зааснаар сонгож нарийвчлалыг тодорхойлно.

7.2.4. Кадастрын зураглал үйлдэх нарийвчлалаас хамааруулж хэмжилт хийх геодезийн багаж, тоног, төхөөрөмжийн төрлийг сонгоно.

7.2.5. Хээрийн хэмжилт хийх багаж, тоног төхөөрөмжийн зай /батерей/ нь хэмжилт үргэлжлэх хугацаанд тасралтгүй байдлыг хангасан байна.

7.2.6. Кадастрын зураглал үйлдэх газарт геодезийн сүлжээний байрлал, өндрийн сүлжээний цэгт судалгаа хийх, шинээр суулгах, байрлал өндрийг тодорхойлоход Геодезийн байнгын цэг тэмдэгт байгуулах ажил БД11-104-106, “1:500, 1:1000, 1:2000, 1:5000 масштабтай байр зүйн зураглалын ажил” БД 11-106-08, (GPS/Глонасс)-ын технологиор Монгол Улсын геодезийн сүлжээ байгуулах үндсэн дүрэм” БНБД 14-101-08-ыг баритлана.

7.3. Нэгж талбар үүсэх газрын хил, зааг, тэдгээрийн эргэлтийн цэгийг тогтоох геодезийн хэмжилтийн аргачлал.

7.3.1. Нэгж талбар үүсэх газрын хил, зааг, тэдгээрийн эргэлтийн цэгийг тогтоох хэмжилтэд нарийвчлалын шаардлага хангах хэмжилтийн триангуляц, полигонометр, трилатриацын аргуудын аль ч аргаар хийж болно.

7.4. Нэгж талбар үүсэх газрын хил, зааг, тэдгээрийн эргэлтийн цэгийг тогтоох геодезийн хэмжилт, боловсруулалтын аргачлал.

7.4.1. Нэгж талбар үүсэх газрын хил, зааг, тэдгээрийн эргэлтийн цэгийг мэдэгдэлд бичигдсэн солбицолын х, у-ийн утгыг хэмжилтийн багажинд гараас оруулна.

7.4.2. Мэдэгдэлд бичигдсэн солбицолын х,у-ийн утгыг GPS-ийн хүлээн авагчаар газар дээр нь солбицолоор хайж тогтооно.

7.4.3. Нэг эргэлтийн цэгт хэмжилтийг 2-3 удаа давтан хийнэ.

7.4.4. Мэдэгдэлд бичигдсэн солбицолын х, у-ийн утгыг тогтоож “+” тэмдэглэж, огтлолцсон цэгт эргэлтийн цэгийг суулгана.

7.4.5. Нэгж талбар үүсэх газрын хил, зааг, тэдгээрийн эргэлтийн цэгийг тогтоох хэмжилтийг байнгын ажиглалтын суурин станцад тулгуурлан үйлдэхэд 30 км –ээс холгүй байна.

7.4.6. Хэмжилтэд 2 долгионы GPS-ийн хүлээн авагч ашиглана.

7.4.7. Хэмжилтийг электрон теодолитын төрлийн багаж ашиглан үйлдсэн бол ойлгогчийн тооноос хамаарсан зай хэмжээг хэтрүүлж болохгүй

7.4.8. “Эзэмших, ашиглах, өмчлөх газрын хил заагийн эргэлтийн цэгийг газарт бэхлэх, тэмдэгжүүлэх” мэдэгдэлд бичигдсэн солбицолоор газар дээр нь хэмжилт хийхэд ямар нэг эд зүйл хашаа, объект байрлаж тэдгээрийн эргэлт нь дээрх мэдэгдэлд бичсэн солбицолтой тохирсон эсхүл нарийвчлалын шаардлага хангасан бол эзэмших, ашиглах, өмчлөх газрын хил заагийн эргэлтийн цэг гэж үзэж болно.

7.4.9. Эзэмших, ашиглах, өмчлөх газрын хил зааг, тэдгээрийн эргэлтийн цэгийг газарт бэхэлж, тэмдэгжүүлж, кадастрын зурагт буулгана.

7.4.10. Эзэмших, ашиглах, өмчлөх газрын хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгээр нэгж талбар үүсгэх талбайд байрлах бүх эд зүйл, хашаа, объектыг хэмжилт хийж кадастрын зурагт буулгана.

7.4.11. “Эзэмших, ашиглах, өмчлөх газрын хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийг газарт бэхлэх, тэмдэгжүүлэх” мэдэгдэлд бичигдсэн солбицолоор газар дээр хэмжилт хийхэд бусдын эзэмшиж ашиглаж байгаа газартай бүтнээр буюу хэсгээр давхцаж байвал давхацсан хэсэгт хил заагийн эргэлтийн цэг бэхлэх, тэмдэгжүүлэх ажил хийгдэхгүй.

7.4.12. Эзэмших, ашиглах, өмчлөх газрын хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийг газарт бэхэлж, тэмдэглэх асуудлыг энэ норм ба дүрмийн 8 дахь хэсгээр зохицуулна.

7.4.13. Эзэмших, ашиглах, өмчлөх газрын хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийг газарт бэхлэх, тэмдэгжүүлэх мэдэгдлийг Хавсралт ... загвараар үйлдэнэ.

7.4.14. Бүх төрлийн бүх ангилалын газарт болон **аймаг, нийслэл, сум, дүүрэг, хотхон, баг, хорооны хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийг газарт бэхлэх, тэмдэгжүүлэх мэдэгдлийг Хавсралт ... загвараар үйлдэнэ.**

7.4.15. Магадлан хэмжилт үйлдэх мэдэгдлийг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтан бичнэ.

7.4.16. Шалгалтын хэмжилт хийх мэдэгдлийг захиалагч байгууллагын эрх бүхий албан тушаалтан бичнэ.

НАЙМ. НЭГЖ ТАЛБАРЫН ХИЛ, ИЙН ШУГАМЫН ЗААГ ТЭДГЭЭРИЙН ЭРГЭЛТИЙН ЦЭГИЙГ ГАЗАРТ БЭХЭЛЖ ТЭМДЭГЛЭХ, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

8.1. Бүх төрлийн бүх ангилалын газрын ерөнхий ба оноосон хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгт Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.12 дахь заалтыг баримтлана.

8.2. Газрын ерөнхий ба оноосон хил, зааг эргэлтийн цэгийн байрлалын тэмдэгтийн загвар, хэмжээ, үйлдэх, суулгах журмыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтоож болно.

8.3. Бүх төрлийн бүх ангилалын газарт болон **аймаг, нийслэл, сум, дүүрэг, хотхон, баг, хорооны хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийг газарт тогтоох геодезийн хэмжилтийг энэ норм ба дүрмийн 7 дугаар хэсгээр зохицуулна.**

8.4. Газрын зориулалтаас үл хамааран хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийг газарт тогтоох хэмжилт хийхэд эргэлтийн цэгийг урьдчилан бэлтгэсэн байна.

8.5. Эргэлтийн цэгт геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын баталсан загвар, геодезийн цэг тэмдэгтээс бусад тэмдэгт ашигласан бол газар дээр ил байх хэсэгт төв цэгийн тэмдэглэгээг хийсэн байна.

8.6. Газрын ерөнхий ба оноосон хил, зааг эргэлтийн цэгт геодезийн цэг тэмдэгт ашиглах бол Геодезийн байнгын цэг тэмдэгт байгуулах ажил БД 11-104-19-ийг баримтлана.

8.7. Газрын хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийг газарт тогтоох хэмжилт хийж олоод эргэлтийн цэгийг суулгахад нарийвчлал алдагдахгүйгээр тэмдэглэгээ хийнэ.

8.8. Газрын хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийг суулгахад нарийвчлал алдагдахгүйгээр тэмдэглэгээг геодезийн хэмжилтээр тогтоосон цэгт 50 см-аас багагүй тойрог эсхүл тэгш өнцөгтийг газар дээр зурж тогтоосон цэгт огтлолцуулж 2 буюу түүнээс дээш шулуун зурж тэмдэглэнэ.

8.9. Газрын хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийг бэлтгэсэн цэгийг суулгана.

8.10. Газрын хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийг газар дээр нь хэмжилт хийж тогтоож тэмдэглэсэн төв нь бэхлэж, тэмдэглэж байгаа эргэлтийн цэгт тэмдэглэсэн төвтэй давхцаж байна.

8.11. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь эзэмших, ашиглах, өмчлөх газрын хил, зааг, эргэлтийн цэгт хашаа барьсан бол газар дээр нь эргэлтийн цэгийг геодезийн хэмжилтээр тогтоох хэмжилттэй нарийвчлалын хувьд тохирч байвал түүнийг эргэлтийн цэг гэж үзэж болно.

8.12. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь эзэмших, ашиглах, өмчлөх газрын хил, зааг, эргэлтийн цэгт хашаа барьсан нь бол газар дээр нь эргэлтийн цэгийг геодезийн хэмжилтээр тогтоох хэмжилттэй нарийвчлалын хувьд зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн бол эргэлтийн цэгийг газар дээр нь бэхэлж, тэмдүүлнэ.

8.13. Газрын хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийг газарт бэхлэж, тэмдэгжүүлэх ажил дууссаны дараа гүйцэтгэгч шалгалтын хэмжилтийг дахин гүйцэтгэнэ.

8.14. Шалгалтын хэмжилтээр газрын хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийг газарт бэхлэж, тэмдэгжүүлсэн цэгт хийсэн хэмжилт “Эзэмших, ашиглах, өмчлөх газрын хил заагийн эргэлтийн цэгийг газарт бэхлэх, тэмдэгжүүлэх” мэдэгдэл болон улсын тусгай хэрэгцээний газрын хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийг газарт бэхлэх, тэмдэгжүүлэх мэдэгдэлд бичигдсэн солбицолтой тохирохгүй эсхүл тухайн масштабын нарийвчлалын шаардлага хангахгүй бол бэхэлсэн цэг тэмдэгтийг газарт бэхлэх, тэмдэгжүүлэх ажлыг дахин гүйцэтгэнэ.

8.15. Газрын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалын газар болон аймаг, нийслэл, сум, дүүрэг, хотхон, баг хорооны хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийг газар дээр геодезийн хэмжилтээр тогтоох бөгөөд газрын гадаргуугаас дээш 1.5 м хүртэл өндөртэй самбарт нэр, эргэлтийн цэгийн дугаар бичиж тэмдэгжүүлж болно.

8.16. Энэ норм ба дүрмийн 8.15-д заасан газрын хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэг нь бие биенээ харах бөгөөд газрын гадаргуугийн нугачаа ихтэй болон харагдахгүй газарт хил заагийн тэмдэглэгээг байрлуулна.

8.17. Тусгай хамгаалалттай газар нутгийн дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөцийн газар, дурсгалт газрын дотоод бүс тус бүрийн хил, зааг, түүний эргэлтийн цэгийг газар дээр бэхлэх, тэмдэгжүүлэхэд энэ норм ба дүрмийн 8.16, 8.17-г баримтлана.

8.18. Энэ норм ба дүрмийн 6.15-ыг ашиглан газрын хил зааг, тэдгээрийн эргэлтийн цэгийг тэмдэгжүүлсэн бол шалгалтын болон магадлан хэмжилт хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

8.19. Бүх ангилалын бүх төрлийн газарт газрын хил, зааг эргэлтийн цэгийг газарт бэхэлж, тэмдэгжүүлсний дараа шалгалтын хэмжилт хийж “Газрын хил зааг, тэдгээрийн эргэлтийн цэгийг газарт бэхэлж, тэмдэгжүүлж хүлээлгэн өгсөн акт үйлдэж, кадастрын зургийг хэвлэж баталгаажуулна.

8.20. Газар эзэмших, ашиглах өмчлөх газрын хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийг газарт бэхэлж, тэмдэгжүүлж хүлээлгэн өгсөн актыг хавсралт ... дагуу үйлдэнэ.

8.21. Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалын газар болон аймаг, нийслэл, сум, дүүрэг, хотхон, баг, хорооны хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгүүдийг газарт бэхлэх, тэмдэгжүүлж хүлээлгэн өгсөн актыг хавсралт.... дагуу үйлдэнэ.

8.22. Уул уурхайн тусгай зөвшөөрөл бүхий талбайн хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийг тогтоох, шав тэмдэг тавихад дээрх шаардлагаас гадна дараах техникийн шаардлагыг хангасан байна.

8.22.1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий уурхайн талбайг тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлд бүртгүүлж уурхайн талбайн хилийн булангийн цэгийн солбицолуудыг тогтоолгож, байнгын шав тэмдэг сулгуулна.

8.22.2. Уул уурхайн болон бусад ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийг эрх бүхий Засаг даргад хүргүүлж газар эзэмших, ашиглах шийдвэрийг Газрын тухай, Ашигт малтмалын тухай хуульд заасан заалтын дагуу гаргуулсан байна.

8.22.3. Уурхайн талбайн хилийн булангийн цэгийн солбицолуудыг газар дээр байгуулах хэмжилтийг энэ норм ба дүрмийн 3 дугаар бүлэгт заасан солбицолын тогтолцоонд үйлдэнэ.

8.22.4. Уурхайн талбайн хилийн булангийн цэгийн солбицолуудыг газар дээр байгуулах хэмжилтийн үр дүнгээр тогтоож, байнгын шав тэмдэг суулгаж баталгаажуулна.

8.22.5. Уурхайн талбайн хилийн булангийн цэгийн солбицолуудыг газар дээр байгуулахдаа 1:1000-ны масштабтай газрын зургийн нарийвчлалыг хангасан байна.

8.22.6. Шав тэмдгийг 1.5 м урттай 50 мм-ээс багагүй хөндлөн огтлолтой төмөр материалаар хийх, газар дээр байрлах цэгийн толгой хэсэгт чагтан тэмдэглэгээ хийсэн байна. Шав тэмдгийн хэлбэрт геодезийн байнгын цэгийг ашиглаж болно.

8.22.7. Шав тэмдгийг бэлтгэх, газарт суулгах, гаднах тэмдэглээс хийх хийхдээ Геодезийн байнгын цэг, тэмдэгт байгуулах ажил БД 11-104-19-ийг дагаж мөрдөнө.

8.22.8. Шав тэмдгийн дээд хэсэгт тусгай зөвшөөрөл, булангийн цэгийн дугаарыг ган хасуураар арилгахгүйгээр тод бичнэ.

8.22.9. Ашиглалтын тусгай зөвшөөрөл нь бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай давхацсан, тусгай хамгаалалттай газар нутаг, ой, усан сангийн хамгаалалтын бүсэд байрлаж байгаа бол уурхайн талбайн хилийн булангийн цэгийн солбицолуудыг тогтоох хэмжилт хийхийг хориглоно.

8.22.10. Шав тэмдгийн солбицол, фото зургийн жагсаалт, кадастрын зураг үйлдэнэ. /Хавсралт .../

8.22.11. Уурхайн талбайн хилийн булангийн цэгийн солбицолыг газарт бэхэлж, тэмдэгжүүлсэн актын И хавсралтын дагуу үйлдэнэ.

8.22.12. Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөл бүхий уурхайн талбайг тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлд бүртгүүлсэнээс хойш 3 сар /90 хоног/-ын дотор уурхайн талбайн хилийн булангийн цэгийн солбицолуудыг тогтоолгож, байнгын шав тэмдэг суулгасан актыг хүргүүлж, хяналт шалгалтын цахим мэдээллийн санд бүртгүүлсэн байна.

ЕС.КАДАСТРЫН ЗУРАГЛАЛЫН БОЛОВСРУУЛАЛТЫН АЖИЛ

9.1. Кадастрын зураглалын технологийн үе шат болох нэгж талбарын хилийн шугамын эргэлтийн цэг, объектын эргэлтийн цэгийг хэмжсэний дараа геодезийн хээрийн хэмжилтийн өгөгдлийг багажнаас өгөгдлийн өргөтгөлийн төрлийг сонгон хуулбарлан авна.

9.2. Геодезийн хээрийн хэмжилтийн багажнаас хуулбарлан авсан өгөгдлийг инженерийн боловсруулалт хийх программ хангамжиндаа оруулж боловсруулалтын ажлыг эхлүүлнэ.

9.3. Кадастрын зураглалын боловсруулалтад Autocad, Autocad civil 3D зэрэг боловсруулалтын шаардлага хангах инженерийн болон газар зүйн боловсруулалтын программ хангамж, тоног төхөөрөмж ашиглана.

9.4. Сонгож авсан инженерийн программ хангамжид багажнаас авсан кадастрын зураглалын хээрийн хэмжилтийн өгөгдлийг оруулж тоон зураг гаргаж авахдаа дараах дарааллаар гүйцэтгэнэ.

9.4.1. Хээрийн хэмжилтийн өгөгдлийг тухайн программын дэлгэц дээр дуудаж оруулан 3D шугаман төрлөөр зурах ба зурахдаа зүүн доод булангаас эхлүүлэн цагийн зүүний дагуу хил заагийн эргэлтийн цэгүүдийг холбож зурна.

9.4.2. Тухайн программын дэлгэц дээр хээрийн хэмжилтийн өгөгдлийн цэгүүдийг холбож зурахдаа зүүн доод булангаас эхлүүлэн цагийн зүүний дагуу тойруулан битүү полигон болгож зурна.

9.4.3. Хээрийн хэмжилтийн өгөгдлийг полигон болгон зурсан 3D зургаа тусгай макро түүл ашигласан бол захиалагчийн нэр, регистрийн дугаар, геодезийн хэмжилт хийхэд тулгуур болгон ашигласан геодезийн сүлжээний цэгийн өгөгдөл, хэмжилт хийсэн огноо, гүйцэтгэсэн аж ахуйн нэр, масштабын хэмжээ, гүйцэтгэсэн, хянасан албан тушаалтны нэр бичиж хэвлэж, гарын үсгээ зурж тамга, тэмдэг дарж баталгаажуулна.

9.4.4. Кадастрын зураглалын хээрийн хэмжилтийн боловсруулалт хийж хэвлэхэд тусгайлан бэлтгэсэн макро түүл /tool/ байхгүй бол хэвлэх загварыг бэлтгэнэ.

9.4.5. Кадастрын зураглалын хээрийн хэмжилтийн боловсруулалт хийж хэвлэхэд бичиг фонд нь Arial, өндөр нь КАДАСТРЫН ЗУРАГ ҮГ Arial-..., газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгчийн нэр, регистрийн дугаар Arial-..., бусад бичиглэл Arial-... –эр бичигдсэн байна.

9.4.6. Кадастрын зургийг А4 эсхүл А3 хэмжээтэй байх бөгөөд 3 хувь хэвлэж захиалагчид 2 хувийг хүлээлгэн өгч, 1 хувийг кадастрын зураглал үйлдсэн байгууллагын архивт хадгална.

9.4.7. Кадастрын зураглал үйлдсэн байгууллага нь кадастрын тоон зургийг архивын нэгж болгон хадгалж болно.

9.5. Бүх төрлийн бүх ангилалын кадастрын зураглалын хээрийн хэмжилтийг боловсруулсан тоон зургийг дүрслэлүүдээр нь давхрага / Layer / -уудад ангилан зураглахад дараах шаардлагуудыг хангасан байна.

9.5.1. Элементүүд нь эхлэл цэгээс төгсгөл цэг, түүнээс эхлэлийн цэгт битүүрсэн полигон /Circle/ байх бөгөөд ба 3D шулуун /Polyline/ байна.

9.5.2. Шулуун /Line/ ба полигон /Circle/- ууд нь давхцаж огтолцохгүй байна.

9.5.3. Нэгж талбарыг үүсгэх полигон /Circle/-ыг зурахдаа зүүн гар талын доод өнцөгт байрлах эргэлтийн цэгээс эхлэн зурсан байна.

9.5.4. Нэгж талбар бүрийн хил заагийн эргэлтийн цэгийг дугаарлахдаа зүүн доод талын зуралт эхэлсэн эргэлтийн цэгээс эхлэн цагийн зүүний эргэлтийн дагуу 1 ... N хүртэл дэс тоогоор дугаарлана.

9.5.5. Нэг нэгж талбарын хил заагийн дугаарлагдсан эргэлтийн цэг нь зэргэлдээ байрлах нэгж талбарын хил заагийн эргэлтийн цэгт өөрөөр дугаарлагдана.

9.5.6. Нэгж талбар бүр нь өөрийн гэсэн хил заагийн эргэлтийн цэг бүрт давхцахгүй дугаартай байна.

9.5.7. Бүх төрлийн бүх ангилалын кадастрын хэвлэсэн зураг дээр хил заагийн эргэлтийн цэгийн дугаарлалтыг ойлгомжтой байдлаар “о” тэмдэгээр дүрслэн үзүүлсэн байна.

АРАВ.КАДАСТРЫН ЗУРАГЛАЛЫН АЖИЛД МАГАДЛАН ХЭМЖИЛТ ХИЙХ

10.1. Бүх төрлийн бүх ангилалын кадастрын зураглалд магадлан хэмжилтийг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хийнэ.

10.2. Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь бүх төрлийн бүх ангилалын кадастрын зургийг геодезийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж гүйцэтгүүлж болно.

10.3. Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь магадлан хэмжилт, түүний боловсруулалтын үр дүнг хариуцна.

10.4. Бүх төрлийн бүх ангилалын кадастрын зурагт магадлан хэмжилт хийхэд энэ норм ба дүрэмийг дагаж мөрдөнө.

10.5. Бүх төрлийн бүх ангилалын кадастрын зургын магадлан хэмжилтийг бүх шатны шүүх, авилгатай тэмцэх газар, цагдаа, төрийн захиргааны төв, төрийн захиргааны, орон нутгийн захиргааны байгууллага болон байгууллага, аж ахуйн нэгж, иргэсээс гаргасан хүсэлт, эсхүл кадастрын зураглал хийх технологийн бүх дамжлага, үе шатанд мэргэжлийн хяналт тавих үед хийнэ.

10.6. Магадлан хэмжилт хийх бэлтгэл ажлыг хангахад энэ норм ба дүрмийн 4 дэх хэсгийг баримтлана.

10.7. Магадлан хэмжилт хийхийн өмнө төрийн цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын мэдээллийн санд үүссэн газрын кадастрын зураг, газар эзэмших, ашиглах, өмчлөхтэй холбоотой баримт бичгийг нягталсан байна.

10.8. Магадлан хэмжилтт хийхдээ энэ норм ба дүрмийн 1.3 дахь хэсгийн 12-т тусгасан масштабын нарийвчлалыг хангаж нэгж талбарт хэмжилт үйлдэнэ.

10.9. Газар, түүний гадаргуу, агаар, хэвлийд баригдсан барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээ болон бусад объект, эд зүйлийн хил зааг, тэдгээрийн эргэлтийн тогтоох, тэдгээрийн харилцан байршилд үнэлэлт өгөх зорилгоор хийнэ.

10.10. Магадлан хэмжилтийн боловсруулалтыг хийж, төрийн цахим мэдээллийн санд үүссэн газрын кадастрын мэдээллийн санд үүссэн газрын кадастрын зураг, түүнд бүртгэлтэй объектын байрлалыг солбицолоор давхцуулж боловсруулж үр дүнг гаргана.

10.11. Магадлан хэмжилт хийж Л хавсралтыг үйлдэнэ.

АРВАН НЭГ.КАДАСТРЫН ЗУРАГЛАЛЫН АЖЛЫГ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

11.1. Кадастрын зураглалын шалгалтын ажлыг гүйцэтгэгч аж ахуйн нэгж нь ажлын үе шат дамжлага бүрд дотоодын шалгалтыг хийнэ.

11.1.1. Кадастрын зураглалын хэмжилт, боловсруулалтын үр дүн, газар, түүний гадаргуу, агаар, хэвлийд баригдсан барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээ болон бусад объект, эд зүйлийн хил зааг, тэдгээрийн эргэлтийн цэгийг тогтоох хэмжилтийн байрлал, өндрийн солбицол зөв эсэх, хүлээлцсэн актын мэдээллийг шалгасан байна.

11.1.2. Тоон зураг дээр шулуун, полигон давхардаагүй байх.

11.1.3. Бүх төрлийн бүх ангилалын кадастрын зураглалд Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан байр зүйн агуулгыг ханасан эсэхийг ын агуулгыг бүрэн тусгасан байна.

11.1.4. Кадастрын зураглалын солбицол, өндрийн нэгдсэн тогтолцоонд нарийвчлал хангасан эсэхийг шалгана.

11.1.5. кадастрын зураглал ба газрын эрхийн бүртгэлийн үнэн зөвийг шалгахдаа заавал газар дээр нь хэмжилт болон тулгалт хийх замаар шалгасан байна.

11.2. Бүх төрлийн бүх ангилалын кадастрын зураглалын ажил гүйцэтгэж дууссаны эцэст дор дурьдсан материалуулыг хүлээлгэж өгнө.

11.2.1. Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалын газар болон аймаг, нийслэл, сум, дүүрэг, хотхон, баг, хорооны хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгүүдийг бэхэлж, тэмдэгжүүлэн хүлээлгэн өгсөн акт, кадастрын зургийн хамт захиалагчид хүлээлгэн өгнө.

11.2.2. Эзэмших, ашиглах, өмчлөх газрын хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийг газарт бэхэлж, тэмдэгжүүлж хүлээлгэн өгсөн акт, кадастрын зургийн хамт хүсэлт гаргагчид хүлээлгэн өгнө.

11.2.3. Уурхайн талбайн хилийн булангийн цэгийн солбицолыг газарт бэхэлж, тэмдэгжүүлсэн акт, шав тэмдгийн жагсаалт, кадастрын зургийн хамт хүсэлт гаргагчид хүлээлгэн өгнө.

11.2.4. Газар, түүний гадаргуу, агаар, хэвлийд баригдсан барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээ болон бусад объект, эд зүйлд хил зааг, тэдгээрийн эргэлтийн цэгийг хэмжилт хийж, сэргээсэн тухай кадастрын зураг, геодезийн хэмжилт хийсэн тэмдэглэлийн хамт хүсэлт гаргагчид хүлээлгэн өгнө.

11.2.5. Магадлан хэмжилт хийсэн тухай тэмдэглэл, кадастрын зургийн хамт хүсэлт гаргагчид хүргүүлнэ.

АРВАН ХОЁР. ХАВСРАЛТУУД

А хавсралт

(заавал)

Эшлэл татсан норм, нормативын баримт бичгийн жагсаалт

1. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2010 онд баталсан “Геоидын өндрийн загвар”, “Масштабын итгэлцүүр”
2. Геодезийн байнгын цэг тэмдэгт, байгуулах ажил” БН11-104-19
3. Хиймэл дагуул “GPS/Глонасс0-ын технологиор монгол улсын геодезийн сүлжээ байгуулах үндсэн дүрэм” БНБД 14-101-08
4. 1:500, 1:1000, 1:2000, 1:5000-ны масштабтай байр зүйн дэвсгэр зураглалын ажил БД 11-106-08
5. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн а/112 тоот тушаалаар батлагдсан 2005 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн эрин бүхий ITRF2008 солбицолг бүх төрлийн байр зүйн болон кадастрын хэмжил, зураглалд ашиглах тухай тушаал
6. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2013 оны 93 дугаар тушаалаар баталсан Нэгж талбарын хилийн эргэлтийн цэг, тэмдэгтийн загвар
7. Төмөр замын зурваст тавих шаардлага MNS 6060:2010
8. Байгаль орчин, Дэд бүтцийн хөгжил, Эрүүл мэндийн сайдын хамтран баталсан 1995 оны тушаал Хүн амын унд, ахуйн усны эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэм
9. Ерөнхий төлөвлөгөөний ажлын зургийн техникийн тэмдэглэгээ
10. Хот байгуулалтын кадастр БД 14-102-19
11. Инженерийн шугам сүлжээний зураглалын ажил БД 11-105-06
12. Агаарын зураглалын ажил БД81-113-13
13. Авто болон төмөр замын геодезийн ажил
14. Барилгын геодезийн ажил БНБД 11-08-06
15. Барилга байгууламжийн судалгааны нийтлэг үндэслэл /инженер геодезийн ажил/ БНБД 110-07-19
16. Эрчим хүч, харилцаа холбооны инженерийн байгууламжийн геодезийн ажил БД 11-120-17
17. Ус дулаан хангамж ариутгах татуургын сүлжээ, үерийн усны байгууламжийн геодезийн ажил БД 11-115-16
18. Барилга, байгууламжийн инженер геодезийн ажил БД 11-103-06
19. Хот суурины гудамж, замын төлөвлөлт БНБД 11-102-06
20. Кадастрын зураглалын ажил БНБД 11-11-16
21. Барилга рот байгуулалтын Сайдын 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 74 дүгээр тушаал. Байр зүйн болон дэвсгэр тоон зураг, инженерийн дэд бүтцийн мэдээллийн санг хөтлөх журам
22. Барилга рот байгуулалтын Сайдын 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 38 дүгээр тушаал. Хот байгуулалтын мэдээллийн сангийн журам

23. Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм БНБД
 24. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тэмдэг, тэмдэглэгээ, дүрэмт хувцас. Ерөнхий шаардлага MNS5851:2008
 25. Усжуулалтын систем, түүний байгууламж БНБД 33-09-10
 26. Хот байгуулалтын мэдээллийн сангийн таних тэмдэг MNS 6736:2018

Б Хавсралт

- Газар-Газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт /газрын гадаргуу, түүний хөрс, ой, ус, ургамал бүхий орон зайн давхаргыг/-ыг,**
Газрын хэвлий – Газрын хэвлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл /Хөрснөөс доош газрын гүн рүү үргэлжлэх орон зай, түүнийг эзлэн орших материаллаг бүх зүйлс /бүх төрлийн чулуулаг, ашигт малтмал болон геологийн бусад биет, түүнчлэн барилга байгууламж/-ийг **ойлгоно.**
- Кадастрын зураглал –**Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтад дурдсанаар ойлгоно.
- Эдлэн газар -** Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад дурдсанаар ойлгоно.
- Нэгж талбар (парсель) -** Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дахь заалтыг,
- Нэгж талбарын дугаар –**Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.16 дугаар зүйл /газар өмчлөх эрх болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийг газрын улсын бүртгэлд бүртгэснийг нотолж, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон дахин давтагдахгүй дугаарыг/-ыг,
- Эргэлтийн цэг -**Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтыг,
- Хамгаалалтын бүс эсхүл зурвас гэдэгт** хориглох, хязгаарлах, эрүүл ахуйн, хамгаалалтын, аюулгүйн бүс эсхү зурвас газрыг -ийг тус тус хамруулж ойлгоно
- Авто зам –**Авто замын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтыг,
Авто замын зурвас газар –Авто замын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь зүйлийг;
- Аэродром -** агаарын хөлгийг байрлуулах, хөөргөх, буулгах, явгалахад зориулж тусгайлан тоногдсон газар болон усан гадаргуу;
- Аэродром орчмын аюулгүйн бүс -** аэродромыг байгуулахдаа нислэгийн аюулгүй ажиллагааг хангах зайлшгүй шаардлагыг үндэслэн тогтоосон тодорхой хэмжээний хуурай газар, усан гадаргуу, орон зай;
- Ой -** мод, бут, сөөг болон бусад ургамал, хаг хөвд, амьтан, бичил биетэн шүтэлцэн орших хам бүрдлийн экологи-газарзүйн онцлог нөхцөл бүхий орчин;
- Ойн сан -** энэ хуулийн 3.1.1-д заасан ой, ой дотор байгаа ойгоор бүрхэгдээгүй болон ойн тэлэн ургахад шаардлагатай талбай бүхий орчин;
- Төмөр замын зурвас газар -** төмөр замын шугамын дагуух технологийн онцлог үйл ажиллагааг явуулах, тээврийн аюулгүй байдлыг хангах зориулалт бүхий газар;

- Төмөр замын аюултай бүс** - галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөн, ачилт, буулгалтын ажил гүйцэтгэдэг дэвсгэр газар;
- Төмөр замын аюулгүйн бүс** - төмөр зам дээр тохиолдож болох осол, сүйрлээс хуулийн этгээд, иргэнд учрах хохирлыг багасгах, аюулгүй нөхцөлийг хангах зориулалт бүхий газар;
- Усны сан бүхий газар** - нуур, цөөрөм, тойром, гол, мөрөн, горхи, булаг, шанд, усан сан, рашаан, намаг, мөстөл, мөсөн голын эзэлж байгаа талбай, тэдгээрийн хамгаалалтын бүсийн газар;
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх** - гадаргын урсацын үндсэн хэсэг бүрэлдэн бий болдог өндөр уулсын бүс, сав газрын эх;
- Усны эх үүсвэр** - ус хангамжийн эх үүсвэрт ашиглаж байгаа усны нөөц болон гол мөрний урсац бүрэлдэх эх;
- Онцгой болон энгийн хамгаалалтын бүс** - усны сан бүхий газар, усны эх үүсвэр, рашааны ордыг хомсдох, бохирдохоос хамгаалах зорилгоор тогтоосон зурвас газар;
- Эрүүл ахуйн бүс** - ус хангамжийн эх үүсвэр болон рашааны ордыг хамгаалах зорилгоор тогтоосон зурвас газар;
- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн бус амралт, зугаалгын газарт** хүүхдийн тоглоомын талбай, парк хамаарна.
- Биеийн тамирын зориулалтын газарт** биеийн тамирын хичээл явуулах, нийтийг хамарсан спортын уралдаан тэмцээн явуулахад зориулан тусгайлан засаж тохижуулсан талбайг хамаарна.
- Цэцэрлэгийн зориулалтын газарт** тусгайлан хайс, хашаагаар хашиж мод, бут, зүлэг тарьж тохижуулсан талбай хамаарна.
- Оршуулгын газарт** оршуулганд зориулж тусгайлан орон нутгийн Засаг даргын захирамжаар олгогдсон хил зааг эргэлтийн цэг бүхий газар хамаарна
- Хог хаягдлын цэгийн зориулалтын газарт** хог хаягдал хаях зориулалтаар орон нутгийн Засаг даргын захирамжаар зөвшөөрөгдсөн хил зааг эргэлтийн цэг бүхий газар хамаарах бөгөөд бодит байдал дээр бусдаас ялгарч буйгаар тооцно.
- Цэвэршүүлэх талбайн газарт**-цэвэрлэх байгууламжид бохир ус татан зайлуулах шугамаас бохир усыг хүлээн авч цэвэрлэх цогц байгууламж, тэдгээрийн хамгаалалтын зурвас бүхий газар хамаарна.

В Хавсралт

ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ҮНДСЭН АНГИЛАЛЫН
 ГАЗАР БОЛОН АЙМАГ,НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРЭГ, ХОТХОН,
 БАГ, ХОРООНЫ ХИЛ, ЗААГ ТЭДГЭЭРИЙН ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙГ
 ГАЗАРТ БЭХЛЭХ, ТЭМДЭГЖҮҮЛЭХ, ШАЛГАЛТЫН
 БОЛОН МАГАДЛАН ХЭМЖИЛТ ХИЙХ МЭДЭГДЭЛ

_____ -ийн
 (газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалын газрын нэр)
 _____ аймаг /нийслэл/-ийн _____ сум /дүүрэг,
 хороо, тосгон/-ийн нутаг дэвсгэрт _____ 20____ оны _____ сарын
 _____ (шийдвэр гаргагчийн нэр)
 _____ өдрийн _____ тоот _____ үндэслэн олгосон _____ м2 /га/
 (гаргасан шийдвэрийн төрөл)
 газрын газрын хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгүүдийг газарт бэхлэх,
 тэмдэгжүүлэх, шалгалтын болон магадлан хэмжилт хийх (аль нь болохыг дугуйлж
 тэмдэглэх)-ийг зөвшөөрөв.

д/д	солбицол		талын урт
	х	у	

.....
 /албан тушаалын нэр/

..... / /
 / албан тушаалтны
 гарын үсэг
 тамга, тэмдэг/

/нэр/

Г.Хавсралт

**ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ҮНДСЭН АНГИЛАЛЫН ГАЗАР
БОЛОН АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРЭГ, ХОТХОН, БАГ,
ХОРООНЫ ХИЛ, ЗААГ ТЭДГЭЭРИЙН ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙГ
ГАЗАРТ БЭХЭЛЖ, ТЭМДЭГЖҮҮЛЖ, ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН АКТ**

1. Эзэмших, ашиглах, өмчлөх газрын хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгүүдийг газарт бэхлэх, тэмдэгжүүлэх мэдэгдэл бичсэн байгууллага _____
2. _____-ийн
3. (газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалын газрын нэр)
4. _____ аймаг /нийслэл/-ийн _____ сум /дүүрэг, хороо, тосгон/-ийн нутаг дэвсгэрт
5. _____ 20 _____ оны _____ сарын _____ өдрийн _____ тоот (шийдвэр гаргагчийн нэр) _____ үндэслэн олгосон _____ м² /га газар (гаргасан шийдвэрийн төрөл)
6. Хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийн тоо _____
7. Газарт бэхэлж, тэмдэгжүүлэх хэмжилт хийсэн огноо _____
8. Эргэлтийн цэгийг газарт бэхэлсэн байгууллагын нэр _____
9. Эргэлтийн цэгийн солбицол тодорхойлоход ашигласан багажны нэр: _____
10. Геодезийн хэмжилт хийхэд ашигласан байнгын цэг, тэмдэгтийн нэр _____
11. Геодезийн хэмжилт хийхэд ашигласан байнгын цэг, тэмдэгтийн солбицолын утга

д/д	Солбицол	
	Х	У
1		
2		

12. Газарт бэхэлж, тэмдэгжүүлсэн хил зааг тэдгээрийн эргэлтийн цэгийн солбицол

д/д	Солбицол		Өндөр
	Х	У	Н
1			
2			
п			

Солбицол тодорхойлсон арга _____

Анхааруулга:

Газрын хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийг геодезийн хэмжилтээр тогтоож, газарт бэхэлж, тэмдэгжүүлсэн тэмдэгтийг хамгаалах асуудлыг хариуцах ба түүнийг устгаж үгүй хийх, зөөж байршлыг өөрчилсөн тохиолдолд тэдгээрийг дахин сэргээх болон түүнээс үүссэн хохирол, нөхөн төлбөрийн холбогдон гарах зардлыг бүрэн хариуцна.

Хүлээлгэн өгсөн:

Газрын хил, зааг, тэдгээрийн эргэлтийн цэгийг газарт тогтоож, бэхэлж, тэмдэгжүүлж хүлээлгэн өгсөн

(Гүйцэтгэгч аж ахуйн нэгж)

/албан тушаал, гарын үсэг, нэр/
/албан тушаал, гарын үсэг, нэр/

/таамга дарж баталгаажуулна/

Хүлээн авсан:

Газрын хил, зааг, тэдгээрийн эргэлтийн цэгийг хүлээн авсан

захалагч байгууллага

/албан тушаал, гарын үсэг, нэр/

/таамга дарж баталгаажуулна/


ИРГЭН.....ОВОГТОЙ.....(РД.....)-ИЙН
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН НЭР (РД.....)-ИЙН

ЭЗЭМШИХ, АШИГЛАХ, ӨМЧЛӨХ ХҮСЭЛТ ГАРГАСАН ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ

Огноо: 2021-06-20

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 20-р хороо

Хашаа Талбайн хэмжээ: 1025.1 квадрат метр



Дугаар	X	Y	Өндөр	Урт	Цэгүүд
1	5320305.232	615902.253	0.000	24.92	1-2
2	5320329.305	615895.802	0.000	40.91	2-3
3	5320341.200	615934.948	0.000	25.12	3-4
4	5320316.979	615941.599	0.000	41.06	4-1

ХЭМЖИЛТ ХИЙСЭН:
ГЕОДЕЗИЙН СҮЛЖЭЭНИЙ ЦЭГИЙН УТГА.
X=..... Y=.....

Зураг үйлдсэн: /Аж ахуйн нэгжийн нэр/
Гүйцэтгэсэн:..... /Инженерийн нэр/
Хянасан:..... /Удирдах албан тушаалтны нэр/

Зургийн масштаб 1:1000 (1 сантиметрт 10 метр багтана)

Е Хавсралт
(заавал мөрдөх)

ЭЗЭМШИХ, АШИГЛАХ, ӨМЧЛӨХ ГАЗРЫН ХИЛ, ЗААГ
ТЭДГЭЭРИЙН ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙГ ГАЗАРТ БЭХЛЭХ,
ТЭМДЭГЖҮҮЛЭХ МЭДЭГДЭЛ

_____ -ны _____
(эцэг /эх/-ийн нэр, нэр, оноосон нэр)
аймаг /нийслэл/-ийн _____ сум /дүүрэг, тосгон/-ийн нутаг
дэвсгэрт _____
(газар эзэмших, ашиглах, өмчлөх шийдвэр)

20____ оны _____ сарын _____ өдрийн _____ тоот захирамж /тушаал/-ийг
үндэслэн олгосон _____ м2 /га/ _____
(нэгдмэл сангийн ангилал, төрөл)
газрыг _____ баг/хороо/-ийн _____
гудамж /хороолол/-ны _____ байр /хашаа, хаалга/-ны дугаар
_____ байршлын газар дээр хил, зааг
тэдгээрийн эргэлтийн цэгүүдийг бэхлэх, тэмдэгжүүлэхийг зөвшөөрөв.

д/д	солбицол		талын урт
	х	у	

..... /..... /
/албан тушаал, гарын үсэг, нэр/

**ЭЗЭМШИХ, АШИГЛАХ, ӨМЧЛӨХ ГАЗРЫН ХИЛ, ЗААГ
ТЭДГЭЭРИЙН ЭРГЭЛТИЙН ЦЭГИЙГ ГАЗАРТ БЭХЭЛЖ,
ТЭМДЭГЖҮҮЛЖ ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН АКТ**

1. Эзэмших, ашиглах, өмчлөх газрын хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгүүдийг газарт бэхлэх, тэмдэгжүүлэх мэдэгдэл бичсэн байгууллага _____
2. Иргэн _____
/ иргэн ургийн овог, эцгийн нэр, өөрийн нэр/
3. Аж ахуйн нэгж, байгууллагын нэр _____
4. Регистрийн дугаар _____
5. Байнга оршин суугаа хаяг _____
6. Утасны дугаар _____
7. Хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэг бэхэлж, тэмдэгжүүлсэн газрын байршлын хаяг _____
8. Газар эзэмших, ашиглах, өмчлөх шийдвэр _____
9. Газар эзэмших, ашиглах хугацаа (жил) _____
10. Эрхийн хэлбэр: (Холбогдох дугаарыг дугуйлна уу)
1.Өмчлөх 2. Эзэмших 3. Ашиглах
8. Хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийн тоо _____
9. Газарт бэхэлж, тэмдэгжүүлэх хэмжилт хийсэн огноо _____
10. Эргэлтийн цэгийг газарт бэхэлсэн байгууллагын нэр:
11. Эргэлтийн цэгийн солбицол тодорхойлоход ашигласан багажны нэр:

12. Геодезийн хэмжилт хийхэд ашигласан байнгын цэг, тэмдэгтийн нэр _____
13. Геодезийн хэмжилт хийхэд ашигласан байнгын цэг, тэмдэгтийн солбицолын утга

д/д	Солбицол	
	Х	У
1		
2		

14. Газарт бэхэлж, тэмдэгжүүлсэн хил зааг тэдгээрийн эргэлтийн цэгийн солбицол

д/д	Солбицол		Өндөр Н
	Х	У	
1			
2			

n			

Солбицол тодорхойлсон арга _____
 Анхааруулга:

Газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгч нь хил зааг тэдгээрийн эргэлтийн цэгийг геодезийн хэмжилтээр тогтоож, газарт бэхэлж, тэмдэгжүүлсэн тэмдэгтийг хамгаалах асуудлыг хариуцах ба түүнийг устгаж үгүй хийх, зөөж байршлыг өөрчилсөн тохиолдолд тэдгээрийг дахин сэргээх болон түүнээс үүссэн хохирол, нөхөн төлбөрийн холбогдон гарах зардлыг бүрэн хариуцна.

Хүлээлгэн өгсөн:

Газрын хил, зааг, тэдгээрийн
 эргэлтийн цэгийг газарт тогтоож,
 бэхэлж, тэмдэгжүүлж
 хүлээлгэн өгсөн

_____ХХК-ны инженер

 /албан тушаал, гарын үсэг, нэр/


 /албан тушаал, гарын үсэг, нэр/

Хүлээн авсан:

Газар эзэмшигч, ашиглагч
 өмчлөгч,

 /албан тушаал, гарын үсэг, нэр/

3 Хавсралт



Ж Хавсралт

QR
КОД

НИЙСЛЭЛИЙН ДҮҮРГИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЛБА

Нэгж талбарын дугаар: _____

Регистрийн дугаар: _____

Хаяг: Аймаг/хот: _____

Зөхийн төрөл: _____

Иргэн, хуулийн этгээдийн нэр: _____

Сум/дуураг: _____

Балхарао: _____

Кадастрын муж: _____

Орчны ТОЙМ

Масштаб 1:1000

Солбицуулалтын систем:

WGS 84/UTM ...N /бүс/

EPSG: 00000

Нэгж талбар

Дугаар	X	Y	Урт	Цэнхүү
1	5320305.232	815902.253	24.92	1-2
2	5320329.305	815895.802	40.91	2-3
3	5320341.200	815934.948	25.12	3-4
4	5320316.979	815941.599	41.06	4-1

Талбайн хэмжээ: квадрат метр

Зургийн хэвцэс: _____ /_____ /

/Гарын үсэг / /Кадастрын агуудай хөрвүүлэн хэрэглэсэн /

Хянасан: _____ /_____ /

/Гарын үсэг / /Дуургийн газар зохион байгуулалтын албаны дарга /

/Тэмдэг дарж баталмаасуулна /

Зургийн масштаб 1:1000 (1 сантиметрт 10 метр багана)

Хэвлэсэн огноо: 2020-00-00

И Хавсралт

ШАВ ТЭМДГИЙН ЖАГСААЛТ

Д/Д	Шав тэмдэгийн дугаар	Газар зүйн солбицол	Тусгай зөвшөөрлийн булангийн цэгийн солбицол	Газар дээр хэмжилтээр солбицол
		В=	Х=	Х=
		λ=	У=	Ү=
1				
2				
3				
4				

Тайлбар:

Булангийн цэгүүдийн фото зураг болон бусад холбогдох материалыг хавсаргана.

**УУРХАЙН ТАЛБАЙН ХИЛИЙН БУЛАНГИЙН ЦЭГИЙН
СОЛБИЦОЛЫГ ГАЗАРТ БЭХЭЛЖ, ТЭМДЭГЖҮҮЛСЭН АКТ**

20 .. оны ...сарын ...өдөр

.....
/аймаг, хот, сум, дүүрэг, тосгон/

- 1 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр
- 2 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий уурхайн талбайг
тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн
бүртгэлд бүртгүүлсэн дугаар
- 3 Уурхайн талбайн хилийн булангийн цэгийн солбицолын хэмжилт
хийсэн аж ахуйн нэр
- 4 Хэмжилт хийсэн аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар...
- 5 Хэмжилт хийхэд ашигласан геодезийн тулгуур цэгийн нэр, дугаар
- 6 Хэмжилт хийсэн багажны мэдээлэл
- 7 Уурхайн талбайн хилийн булангийн цэгийн шав тэмдэгийн тоо

**УУРХАЙН ТАЛБАЙН ШАВ ТЭМДЭГ
ХҮЛЭЭН АВСАН:**

.....
/Ашигт малтмалын тусгай
зөвшөөрөл эзэмшигчийн нэр/

.....
/Гарын үсэг/

.....
/овог, нэр/

ХЭМЖИЛТ ХИЙСЭН:

.....
/Геодези, зураг зүйн үйл
ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрөтэй аж ахуйн нэгжийн нэр/

.....
/Гарын үсэг/

.....
/овог нэр/

К Хавсралт

ГЕОДЕЗИЙН ХЭМЖИЛТ ХИЙСЭН ТЭМДЭГЛЭЛ

1. Хэмжилт хийлгэх хүсэлт гаргасан байгууллага, аж ахуйн нэгж, иргэний нэр, регистрийн дугаар _____
2. Газар эзэмших, ашиглах, өмчлөх (доогуур зурах) _____
(шийдвэр гаргагчийн нэр) 20__ оны ____сарын ____өдрийн _____ шийдвэрээр _____ м² /га/
3. Байршлын хаяг _____
4. Газар, түүний гадаргуу, агаар, хэвлийд баригдсан барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээ болон бусад объект, эд зүйлийн хил зааг, тэдгээрийн эргэлтийн цэгийг /аль нь болохыг доогуур зурах/ тогтоох хэмжилт хийлээ.
5. Геодезийн хэмжилт хийсэн тэмдэглэл нь кадастрын зургийн хамт хүчинтэй.
6. Хэмжилтээр тогтоогдсон зай хэмжээ: _____

7. Бусад тэмдэглэл _____

Тайлбар: Геодезийн хэмжилтийн талаар ямар нэг үнэлэлт, дүгнэлт өгөхгүй.

Хэмжилт хийсэн аж ахуйн нэгжийн нэр _____

Хэмжилт хийсэн мэргэжилтэн _____

(албан тушаал) (гарын үсэг (эцэг, эхийн нэр, нэр)

Хэмжилтийг хянасан захиралын нэр _____

(албан тушаал) (гарын үсэг (эцэг, эхийн нэр, нэр)

Жич: Тамга дарж баталшаажуулна

Л Хавсралт

МАГАДЛАН ХЭМЖИЛТ ХИЙСЭН ТЭМДЭГЛЭЛ

1. Магадлан хэмжилт хийлгэх тухай хүсэлт гаргасан

- (байгууллага, аж ахуйн нэгж, иргэний нэр, регистрийн дугаар)
2. Магадлан хэмжилт хийсэн байгууллагын нэр (Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр) _____
3. Магадлан хэмжилт хийсэн талаар тэмдэглэл

- (Газрын хил, зааг, тэдгээрийн эргэлтийн цэг, барилга, объект, эд зүйлс аль нь болох бичих)
4. Магадлан хэмжилт хийхэд байлцсан _____
- (Байгууллага, аж ахуйн нэгж, иргэн)
5. Аж ахуйн нэгж, байгууллагын нэр _____
6. Регистрийн дугаар _____
7. Магадлан хэмжилт хийж буй газрын байршлын хаяг _____
8. Утасны дугаар _____
9. Хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэг бэхэлж, тэмдэгжүүлсэн газрын байршлын хаяг _____
10. Газар эзэмших, ашиглах, өмчлөх шийдвэр

11. Эрхийн хэлбэр: (Холбогдох дугаарыг дугуйлна уу)
1.Өмчлөх 2. Эзэмших 3. Ашиглах
12. Магадлан хэмжилт хийсэн газрын хил, зааг тэдгээрийн эргэлтийн цэгийн тоо _____
13. Магадлан хэмжилт хийсэн _____
- (нэгж талбарт байрлах барилга, объект, эд юмсын нэр)
14. Магадлан хэмжилт хийсэн огноо _____
15. Эргэлтийн цэгийн солбицол тодорхойлоход ашигласан багажны нэр _____
16. Геодезийн хэмжилт хийхэд ашигласан байнгын цэг, тэмдэгтийн Нэр _____
17. Геодезийн хэмжилт хийхэд ашигласан байнгын цэг, тэмдэгтийн солбицолын утга

	Солбицол		Н
	Х	У	
1			

--	--	--	--

18.Магадлан хэмжилтээр тогтоогдсон нөхцөл:

Тайлбар: Магадлан хэмжилтийн боловсруулалтын үр дүнгээр гарсан тоон утгыг тайлбарын хамт бичнэ. Хэмжилтийн үр дүнд дүгнэлт өгөхгүй.

Магадлан хэмжилт хийсэн байгууллагын нэр _____

Магадлан хэмжилт хийсэн мэргэжилтэн _____

_____ (албан тушаал) _____ (гарын үсэг) _____ (эцэг, эхийн нэр, нэр)

Магадлан хэмжилтийг хянасан албан тушаалтан _____

Магадлан хэмжилт хийхэд байлцсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэний нэр, регистрийн дугаар _____

_____ (албан тушаал) _____ (гарын үсэг) _____ (эцэг, эхийн нэр, нэр)

Газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгч байгууллага, аж ахуйн нэгж, иргэний нэр, регистрийн дугаар _____

_____ (албан тушаал) _____ (гарын үсэг) _____ (эцэг, эхийн нэр, нэр)

Тайлбар:

1. Магадлан хэмжилт хийхэд оролцсон байгууллага, аж ахуйн нэгж, иргэн бүгд гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

НОМ ЗҮЙ

1. Ашигт малтмалын тухай хууль
2. Авто замын тухай хууль хууль
3. Барилгын тухай хууль
4. Байгаль орчныг хамгаалах тухай хууль
5. Газрын тухай хууль
6. Газрын хэвлийн тухай хууль
7. Геодези, зураг зүйн тухай хууль
8. Гамшгаас хамгаалах тухай хууль
9. Иргэний нисэхийн тухай хууль
10. Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль
11. Ойн тухай хууль
12. Төмөр замын тээврийн тухай хууль
13. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
14. Усны тухай хууль
15. Харилцаа холбооны тухай хууль
16. Хилийн тухай хууль
17. Хог хаядлын тухай хууль
18. Хууль тогтоомжийн тухай хууль
19. Цөмийн энергийн тухай хууль
20. Эрчим хүчний тухай хууль
21. Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоол
22. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаал /Газар эзэмших ашиглах эрхийг гэрчилгээ олгох журам/
23. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2009 оны 224 дүгээр тушаалаар баталсан “Газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл хөтлөх журам
24. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2010 оны 16 дугаар тушаалаар баталсан “Нэгж талбар дугаарлах журам”
25. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2011 оны 171 дүгээр тушаалаар баталсан Газрын кадастрын мэдээллийн санг ажлуулах журам”
26. Барилгын зураг төсөл зохиох, угсралтын ажилд мөрдөх